



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: (976) 51-267168, Факс: (976) 11-312315,
E-mail: info@mrt.d.gov.mn, http://www.mrt.d.gov.mn

2022.07.25 № 10а/3406

танай _____-ны № _____-т

Г "АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" Г
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ Б.ГҮРСОРОНЗОН
ТАНАА

Тус яамтай байгуулсан "Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ"-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт болон тус газрын үйл ажиллагаанд 2022 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын товч тайланг хүргүүлэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлантай танилцаж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана уу.

Хавсралт 53 хуудастай.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙН ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
ЗАМ, ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА _____ Д.ЭНХ-АМГАЛАН



080032544

**“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД 2022 ОНЫ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2022.07.06

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Зам, тээврийн хөгжлийн яамнаас “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-тай байгуулсан “Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ”, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт болон тус газрын үйл ажиллагаанд 2022 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар зөвлөмж боловсруулах замаар яам болон “АТҮТ” ТӨҮГ-ын удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах, гарсан дүгнэлт зөвлөмжийг дараагийн бодлого, шийдвэр, төлөвлөгөөнд тусгах, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Хоёр. Үндэслэл, арга зүй

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2021 оны 374 дүгээр тогтоол, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг тус тус баримталсан.

Тус газрын үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд дараах баримт бичгийг хамруулсан.
Үүнд:

- “Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ”-г хэрэгжүүлэх 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт;
- Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт;
- Монгол улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний биелэлт;
- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт;
- Зам, тээврийн хөгжлийн Сайдын тушаалын биелэлт;
- Сайдын зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлт;
- Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллахаар байгуулсан “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт;
- Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийн үнэлгээ;
- Шилэн дансны мэдээлэл гэсэн 9 үзүүлэлтийг хамруулсан болно.

Гурав. Танилцуулга

Тус газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ дээрх 9 үзүүлэлтээр дүгнэлээ. Үүнд:

3.1. “Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ”-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт:

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 76 дугаар тушаалаар Автотээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхээс 7 чиг үүргийг гэрээний үндсэн дээр “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-т шилжүүлэн гүйцэтгүүлж байна.

Энэ хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яам "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-тай "Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ"-г жил бүр байгуулж, гэрээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулдаг ч 2022 оны гэрээ, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг өнөөдрийг хүртэл батлуулаагүй байна. 2021 онд байгуулсан "Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ"-ний хугацаа дуусаж, 2022 онд гэрээг шинэчлэн байгуулаагүй ч гэрээний үндсэн дээр чиг үүрэг шилжсэн 7 ажил, үйлчилгээг тасралтгүй зохион байгуулж байгаа тул гэрээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд тусгасан арга хэмжээний биелэлтийг 2022 оны эхний хагас жилийн байдлаар үнэллээ.

Уг төлөвлөгөөнд 21 зорилтын хүрээнд 72 арга хэмжээ тусгаснаас 2022 оны эхний хагас жилийн байдлаар "үр дүнтэй" буюу бүрэн хэрэгжсэн 15, "тодорхой үр дүнд хүрсэн" буюу 90%-тай 3, 70%-тай 36, "эрчимжүүлэх шаардлагатай" буюу 50%-тай 8, "үр дүнгүй" буюу 30%-тай 7 арга хэмжээ байгаа ба хэрэгжилт **71.0** хувьтай байна.

"Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ"-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2022 оны эхний хагас жилийн байдлаар хүснэгтээр харуулбал:

| № | Төлөвлөгөөнд тусгагдсан нийт арга хэмжээ | Үүнээс хэрэгжилтийн байдал /хувиар/ | | | | | | | Биелэлт /хувиар/ |
|---|--|-------------------------------------|----|----|----|----|---|------------------|------------------|
| | | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | Хугацаа болоогүй | |
| 1 | 72 | 15 | 3 | 36 | 8 | 7 | - | 3 | 71.0 |

"Эрчимжүүлэх шаардлагатай" буюу 50%-тай 8 арга хэмжээ:

1. "Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр"-т тусгагдсан Автотээврийн үндэсний төвөөс хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, улирал бүр яаманд тайлагнах /1.1.2/

Биелэлт: "Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний төлөвлөгөө"-ний биелэлтийг нэгтгэн гаргаж, ЗТХЯ-нд 2022 оны 1-р улирлын байдлаар 2022.03.24-ны өдрийн 1/379, эхний хагас жилийн байдлаар 2022.06.13-ний өдрийн 1/791 тоот албан бичгээр хүргүүлж, хэрэгжилт, үр дүнг тайлагнасан.

Тус хөтөлбөрт үйлдвэрийн газраас хэрэгжүүлэхээр нийт 14 ажил хяналтад байгаагаас бүрэн хэрэгжсэн 100%-3, 70%-тай 4, 30%-тай 7 ажил байна. Дунджаар 56,4 хувийн хэрэгжилттэй байна.

2. Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг тогтмол зохион байгуулах.

Биелэлт: Тус үйлдвэрийн газрын 2022 оны авлигын эсрэг төлөвлөгөөг батлуулсан. Төлөвлөгөөний дагуу Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран 2022.02.23-нд үйлдвэрийн газрын шинээр томилогдсон удирдах албан хаагчид болон ашиг сонирхлын мэдүүлэг гаргадаг албан хаагч нарт авлигын эсрэг хууль тогтоомж, авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор цахим сургалт, 2022.03.04-нд үйлдвэрийн газрын нийт удирдах албан тушаалтнуудад "Авлигын гэмт хэрэг" сэдэвт сургалтуудыг зохион байгуулсан. Авлигын гэмт хэрэг, зөрчлийн илрүүлэлт, авлигын эсрэг үйл ажиллагаанд иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор техникийн хяналтын үзлэгт орж байгаа тээврийн хэрэгслүүдэд иргэд, аж ахуйн нэгжээс өргөдөл гомдол хүлээн авах 110 дугаарын утасны сурталчилгаа бүхий авто стикерыг байршуулан ажиллаж байна.

3. Хот хоорондын нийтийн тээврийн замналын паспорт хөтлөх /1.3.2/

Биелэлт: Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар хот хоорондын нийтийн тээврийн 109 чиглэл батлагдсан бөгөөд 100 чиглэлийн замналын паспортыг бүрэн хөтөлж

мэдээллийн санг үүсгэсэн. Үлдсэн 9 чиглэлийн замналын паспортыг 2022 онд багтаан хийхээр төлөвлөн холбогдох ажлуудыг хийж байна.

4.Тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйл ажиллагаанд тоон гарын үсгийг нэвтрүүлэх. /1.12.4/

Биелэлт: Тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн хийхэд шаардлагатай сервис солилцох тоон гарын үсгээр баталгаажсан албан хүсэлтийг хүлээн авч, гэрчилгээний төлбөрийг цахимаар гүйцэтгэх боломжийг бүрдүүлсэн. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн VRS систем дээр цахим хүсэлтийн хөгжүүлэлтийг бүрэн хийж дуусгасан. Дээрх цахим хүсэлт нэвтрүүлэхтэй холбоотой журмын төслийг ТХБХ боловсруулан ажиллаж байна.Тоон гарын үсгийн төст хийгдэж программ хөгжүүлэлт хийгдэж дууссан.

5. ЗТХЯ болон үйлдвэрийн газрын гадна талбайд байрлуулсан нарны эх үүсвэрийн туршилт судалгааны ажил гүйцэтгэх. /1.13.4/

Биелэлт: ЗТХЯ-ны гадна талбайд 40квт нарны эх үүсвэр суурилуулах” төслийн гүйцэтгэгч “Дүйнхэр тэргүүн” ХХК-тай хамтран судалгааны ажлыг эхлүүлсэн Судалгааны ажлын даалгаврын хүрээнд ONGRID системийн цахилгаан үйлдвэрлэлийн өдөр тутмын үзүүлэлт, туршилтын хугацаан дах Улаанбаатар хотын цаг уур, агаарын бохирдолын хэмжээ, явган замын халаалтын системийн ажиллагаа зэрэг мэдээллийг цуглуулсан. Мөн нарны хөвтөн дээр унасан цас, түүний цэвэрлэх арга технологи зэргийг судлан боловсруулж байна. Тус яамны эрчим хүчний хэрэглээний талаар дэлгэрэнгүй мэдээллийг Засгийн газрын байрнуудын нийтлэг үйлчилгээний газар УТҮГ-аас авч судалгааны мэдээлэл боловсруулалт хийж байна. ЗТХЯ-нд 1/736 тоот албан бичгээр хугацаа сунгах хүсэлт явуулсан.

6. Дотоодын ачаа тээврийг бүртгэлжүүлэх, програм хангамжийг улсын хэмжээнд нэвтрүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах /1.18.1/

Биелэлт: Дотоодын ачаа тээврийн цахим системийн мобайл апп хөгжүүлэлтийг Андроид болон IOS үйлдлийн системд зориулан хийж гүйцэтгэж дууссан. Андроид гар утсанд зориулагдсан хувилбар google playStore, IOS үйлдлийн системтэй гар утас болох iphone-д зориулагдсан хувилбар AppStore-д байршуулсан. Орон нутгийн автотээврийн салбар төвүүдэд мэдээлэл хүргүүлсэн.

7.LPG хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх стандартад холбогдах байгууллагуудаас саналыг авч Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлэх. /1.20.3/

Биелэлт: Хийгээр ажилладаг автотээврийн хэрэгслийн хаягдал утаан дахь хорт бодис, нэмэлт шаардлагыг шалгах талаар стандартын төслийг боловсруулсан. Холбогдох байгууллагуудаас санал авахаар төлөвлөж байна.

8.Байгууллагынхаа ажилтан, албан хаагчдын тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэн, албан хэрэг хөтлөлтөд ашиглаж, тоон гарын үсэг болон QR кодоор баталгаажуулсан цахим албан бичиг солилцоог бүрэн хэмжээнд нэвтрүүлэх./1.21.6/

Биелэлт: 2022.05.01-ний өдрөөс цахим гарын үсгийн тухай хууль мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан тус үйлдвэрийн газар нь “Үндэсний Дата Төв” УТҮГ-тай тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, хамтран ажиллах гэрээ байгуулан зохих албан тушаалтнуудад нийт 125 ширхэг тоон гарын үсгийн гэрчилгээг олгоод байна.

“Үр дүнгүй” буюу 30%-иар үнэлэгдсэн 7 арга хэмжээ:

1.Үйлдвэрийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийх /1.1.6/

Биелэлт: Хяналт-шинжилгээ, дотоод аудитын албаны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1.3, 1.1.4 дэх заалт, дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний 1.3, 1.6 дахь заалтуудыг үндэслэн Зорчигч тээврийн хэлтсийн Мэргэшсэн жолоочийн тасагт

2022.03.23-наас 2022.04.01-ний өдрүүдэд, Сонгинохайрхан зорчигч тээврийн төвд 2022.05.03-05-ны өдрүүдэд, Сонгинохайрхан техникийн хяналтын үзлэгийн төвд 2022.06.06-08-ний өдрүүдэд санхүүгийн аудит хийж холбогдох зөвлөмжүүдийг хугацаатай өгч ажиллаж байна.

2. Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ (RFID)-г бүрэн нэвтрүүлж, татвар даатгал, төлбөр тооцоо, бүртгэл хяналтын үйл ажиллагааг сайжруулах. /1.10.2/

Биелэлт: Монгол улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолын 4 дэх заалтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ /RFID/-г урьдчилан бэлгэх, тээврийн хэрэгсэлд байрлуулах, бүртгэх үйл ажиллагааны 2022 оны нарийвчилсан төлөвлөгөө"-ний санал авах бичиг 2022.02.18-ны өдрийн 04/728 тоотор ирүүлсэн бөгөөд санал хүргүүлэн хамтран ажиллаж байна.

"Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ (RFID tag)-г урьдчилан бэлтгэх, тээврийн хэрэгсэлд байрлуулах, бүртгэх үйл ажиллагааны 2022 оны нарийвчилсан төлөвлөгөө" ЗТХЯ дээр боловсруулагдаж байна. Мөн техникийн хяналтын үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгсэлд RFID шошго суурилуулах ажлын хэсэг ЗТХЯ дээр байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд үйлдвэрийн газраас шаардлагатай мэдээллүүдийг гарган өгч хамтран ажиллаж байна.

3. Ховд болон Орхон аймагт автобуудлын барилгыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барьж байгуулах /1.11.1/

Биелэлт: Орхон аймгийн автотээврийн төвийн автобуудлын барилгын ажлыг тус аймгийн орон нутгийн санхүүжилтээр 2022-2023 онд барьж байгуулахаар төлөвлөж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг цахим хэлбэрээр 2022.01.18-ны өдөр зарлаж, 2022.02.18-ны өдөр нээсэн. Тендерт оролцогч "Шинжүү" ХХК шалгарсан. Гэрээний дагуу барилгын ажлыг 2022.05.18-ны өдөр эхлүүлсэн бөгөөд 621 м.кв талбайн суурийг ухаж ул бетон авах бэлтгэл ажил төлөвлөгөөний дагуу хийгдэж байна.

4. Ашиглалтаас хасагдсан автомашин, түүний эд ангийг устгах, дахин боловсруулах талаар санал боловсруулах. /1.16.1./

Биелэлт: Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй авто үйлчилгээний байгууллага, уул уурхай, ашигт малтмал, хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамруулан тэдгээрийн ажил үйлчилгээний явцад үүссэн аюултай хог хаягдлыг судалгааг гарган санал боловсруулан 2021.06.02-ны өдрийн 2/690 тоот албан бичгээр ЗТХЯ-ны АТБХЗГ-т хүргүүлсэн. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй авто үйлчилгээний байгууллагын хог хаягдлыг судалгааг 2022 оны байдлаар шинэчлэн авахаар ажиллаж байна.

5. Улс, хот хоорондын ачаа, зорчигч тээврийн ААНБ-аас ирсэн хүсэлтийн дагуу "ХАБЭА-н мэдлэг олгох нийт ажилтны сургалт", "Ажил олгогч эздийн сургалт" зохион байгуулах. /1.17.2/

Биелэлт: Үйлдвэрийн газрын нийт ажилтнуудад ХАБЭА -н сургалт явуулж байгаатай холбогдуулан салбарын хэмжээнд явуулах сургалтыг 3-4-р улиралд зохион байгуулах бэлтгэл ажлыг бүрэн хангасан.

6. Байгууллагынхаа хэмжээнд кибер (мэдээллийн) аюулгүй байдлын эрсдэлийн иж бүрэн шинжилгээ, үнэлгээ хийлгэж, кибер (мэдээллийн) аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо бүрдүүлэх, аюулгүй байдлын архитектураа төлөвлөх талаар цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх. /1.21.2/

Биелэлт: Тус үйлдвэрийн газрын Мэдээллийн технологийн хэлтсээс "SSSC" ХХК-ийн мэдээллийн аюулгүй байдлын мэргэжилтэнтэй холбогдож, эрсдэлийн үнэлгээ хийх цар хүрээг тогтоосон. Уг зөвлөх үйлчилгээтэй холбоотой зардлыг шийдвэрлэхээр ТӨБЗГ-т 2022.02.18-ний өдрийн А-1/310 тоот бичгээр хүсэлт хүргүүлсэн. ТӨБЗГ-аас шаардлагатай

тоног төхөөрөмжийг сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаар борлуулсны орлогын эх үүсвэрээс санхүүжүүлэхийг чиглэл болгосон. Үүнтэй холбогдуулан ХНХЯ-нд 2022.04.15-ний өдрийн 2/490 албан бичгээр улсын дугаарын дуудлага худалдаанаас төвлөрсөн сангаас шийдвэрлүүлэхээр хүсэлт хүргүүлсэн. ХНХЯ-наас 2022.04.29-ний өдрийн 01/1176 тоот албан бичгээр дээрх зардлыг шийдвэрлэх хөрөнгийг автотээврийн хэрэгслийн сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаар борлуулсны орлогоос санхүүжүүлэх нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нийцэхгүй байгаа тул боломжгүй байна гэсэн хариу ирүүлсэн.

7. Байгууллагынхаа нийт компьютерын 30-аас дээш хувийг албан ёсны байнгын ашиглах эрх (лиценз)-тэй үйлдлийн систем болон оффисын программ хангамжтай болгож, аюулгүй байдлыг хангах. /1.21.3/

Биелэлт: Үйлдвэрийн газарт ашиглагдаж байгаа зөөврийн болон суурин компьютерүүдийн 30 хувь буюу 140 ширхэг компьютерт шаардлагатай лицензийн үнийн саналыг Zeisssoftware Digital Limited LLC, 3Эксомик дөвелопмент ХХК, "Ашим" ХХК, "Мобинет" ХХК зэрэг албан ёсны лиценз нийлүүлэгч аж ахуй нэгжүүдээс үнийн санал аван төсөвт тодотгол оруулах саналыг хүргүүлээд байна.

3.2. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт:

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд автотээврийн чиглэлээр 4 арга хэмжээ тусгагдсанаас 2022 оны эхний хагас жилийн байдлаар "үр дүнтэй" буюу зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн 1, "тодорхой үр дүнд хүрсэн" буюу 70%-тай 1, "эрчимжүүлэх шаардлагатай" буюу 50%-тай 1, "үр дүнгүй" буюу 30%-тай 1 арга хэмжээ байгаа ба хэрэгжилт 62.5%-тай байна.

| Нийт арга хэмжээ | Үүнээс хэрэгжилтийн хувиар | | | | | | Биелэлт /хувиар/ |
|------------------|----------------------------|----|----|----|----|---|------------------|
| | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | |
| 4 | 1 | - | 1 | 1 | 1 | - | 62.5 |

"Эрчимжүүлэх шаардлагатай" буюу 50%-тай 1 арга хэмжээ:

1. Цахилгаан болон байгалийн хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн цэнэглэх сүлжээг ШТС, үйлчилгээний газруудыг түшиглэн төр хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна. / 3.6.3/

Биелэлт: "ЗТХС-тай 21 аймаг, нийслэлийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээнд тусгав. "Моннис моторс" ХХК 2022 онд 4 байршилд цахилгаан тээврийн хэрэгсэл цэнэглэх байгууламж барихаар төлөвлөж байгаагаас Сүхбаатар дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэр дэхь Моннисын авто засварын төвд өрдийн 2 ширхэг цахилгаан тээврийн хэрэгсэл цэнэглэгчийг ашиглалтад оруулж үйлчилгээнд ашиглаж байгаа бөгөөд өндөр хүчин чадалтай 2 цэнэглэгч байгууламжийн тоног төхөөрөмжийг захиалсан боловч улс хоорондын тээвэрлэлтээс шалтгаалан түр хойшлоод байна.

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын нийтийн хэрэгцээний авто зогсоолд 1 удаад 8 цахилгаан тээврийн хэрэгсэл цэнэглэх байгууламжийг барьж ашиглалтад оруулсан. Улаанбаатар хотын 8 цэгт цахилгаан тээврийн хэрэгсэл цэнэглэх байршлыг тогтоож ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, барьж байгуулах санхүүжилтийг шийдвэрлэх чиглэлээр нийслэлийн холбогдох байгууллагууд ажиллаж байна. Энэ оны эхний 5 сарын байдлаар 11 аймагт 15, Улаанбаатар хотод 133 хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл импортоор орж ирсэн нь хэрэглээ нэмэгдээгүй хийгээр цэнэглэх байгууламжийг нэмж барих нь үр ашиггүй гэсэн дүгнэлтэд хүрч хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд хүлээлтийн байдалтай байна.

" Үр дүнгүй" буюу 30%-ийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ:

2.Замын-Үүд, Сэлэнгэ, Булган, Орхон, Говь-Сүмбэр, Дорнод, Сүхбаатар, Дундговь, Өвөрхангай, Ховд, Говь-Алтай аймгийн төвд зорчигч тээврийн автобуудал байгуулна;/ 3.6.3.2.1/

Биелэлт: Төсвийн тухай хуульд Орхон аймагт автобуудал байгуулах 5 тэрбум төгрөгийн төсөвт өртгийг тусгасан. Тус автобуудлыг байгуулах 1,2 га газрын асуудлыг шийдвэрлэсэн. Автобуудлын барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Барилгын ажил хийгдэж байна.Ховд аймагт "Зорчигч тээврийн Ховд" ХХК нь өөрийн санхүүжилтээр автобуудал барьж байгаа бөгөөд барилгын гүйцэтгэл 80%-тай байна."Бүрд чандмань" ХХК-иас Хэнтий аймгийн Хэрлэн сумд автобуудал, мөн "Гэээгт" ЗГБХН-ээс Говьсүмбэр аймгийн төвд одоогоор үйл ажиллагаа явуулж байгаа байранд өргөтгөл хийж автобуудал байгуулах санал ирүүлснийг Байгаль, орчин, аялал жуулчлалын сайд,Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А\267, А\143 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн 2022 оны 05-р сарын 16-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэв.

3.3. Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний биелэлт:

| Нийт арга хэмжээ | Үүнээс хэрэгжилтийн хувиар | | | | | | Биелэлт /хувиар/ |
|------------------|----------------------------|----|----|----|----|---|------------------|
| | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | |
| 1 | - | - | - | - | - | 1 | 0.0 |

"Хэрэгжээгүй" тасарсан 1 арга хэмжээ:

Олон улс, улсын чанартай авто замын дагуу түр зогсох талбайг 100 км тутамд барьж байгуулах ажлыг эхлүүлэх /3.4.4. МУТЖҮЧ-8.1.3, ЗГҮАХ-3.4.6

Биелэлт: Улсын чанартай авто замын дагуу хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд

- Багануур дүүрэгт "Минимакс цогцолбор",
- Ховд аймгийн Дарви сумын нутаг дэвсгэрт "Бумбат цогцолбор",
- "Алфароуд" ХХК нь Төв аймгийн Баян сумын нутагт өөрийн хөрөнгөөр авто замын дагуу үйлчилгээний цогцолбор,
- "Нутаг хүнс трейд" ХХК нь Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутаг дэвсгэрт үйлчилгээний цогцолбор, нийт 4 цогцолбор ашиглалтад оруулсан.

"Заяын өгөөж" ХХК Архангай аймгийн Цэнхэр сумд, "Драгон" холдинг Увс аймгийн Зүүнхангай сумд, "Исун мод тур" ХХК Хэнтий аймгийн Жаргалтхаан сумд, "Баян дойт" ХХК Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумд үйлчилгээний цогцолбор байгуулах санал, ТЭЗҮ ирүүлснийг хэрэгжих боломжтой гэж үзэн хамтран ажиллах гэрээ байгуулсан.

"Бүрд чандмань" ХХК-иас Хэнтий аймгийн Хэрлэн сумд замын дагуух цогцолбор, автобуудал, мөн "Гэээгт" ЗГБХН-ээс Говьсүмбэр аймгийн төвд одоогоор үйл ажиллагаа явуулж байгаа байранд өргөтгөл хийж замын дагуух цогцолбор, автобуудал байгуулах санал ирүүлээд байна.

3.4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт:

Тайлант хугацаанд тус газарт хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр 4 үүрэг өгөгдсөнөөс "бүрэн хэрэгжсэн" 1, "хэрэгжих шатанд" буюу 70%-тай 2, "хэрэгжилт хангалтгүй" буюу 30%-тай 1 арга хэмжээ байгаа ба хэрэгжилтийн дундаж 67.5%-тай байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг эрхзүйн актуудаар ангилан хувиар илэрхийлбэл:

| № | Эрхзүйн актын нэр | Нийт арга хэмжээ /заалт/ | Үүнээс хэрэгжилтийн байдал /хувиар/ | | | | Хугацаа болоогүй | Биелэлт /хувиар/ |
|---|-------------------|--------------------------|-------------------------------------|----|----|---|------------------|------------------|
| | | | 100 | 70 | 30 | 0 | | |
| | | | | | | | | |

| | | | | | | | | |
|----|--------------------------------|---|---|---|---|---|---|------|
| 2. | Ерөнхийлөгчийн зарлиг | 1 | - | - | 1 | - | - | 30.0 |
| 5 | Засгийн газрын албан даалгавар | 3 | 1 | 2 | - | - | - | 80.0 |
| | Дүн | 4 | 1 | 2 | 1 | - | - | 67.5 |

“Хэрэгжилт хангалтгүй” 30-тай 1 арга хэмжээ:

| № | Эрх зүйн актын нэр, агуулга, огноо, дугаар | Заалт | Хэрэгжилтийн байдал |
|------------------------------|---|--|---|
| Ерөнхийлөгчийн зарлиг | | | |
| 1 | 2018_46. Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай / 2018-05-23 | 3. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ нь байгууллагынхаа гадна нэр, хаягийг кирилл болон үндэсний бичгээр бичиж, байршуулсан. Мөн үйлдвэрийн газрын Улаанбаатар хот дахь техникийн хяналтын үзлэгийн болон зорчигч тээврийн төвүүдийн хаягийг кирилл болон үндэсний бичгээр бичиж, шинэчилсэн. Түүнчлэн орон нутгийн зарим салбар төвүүдийн хаягийг үндэсний бичгээр бичиж байршуулаад байна. Үйлдвэрийн газрын цахим хуудасны “Ил тод байдал” цэсний “Хүний нөөц хэсэг”-т “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр” дэд цэс нээж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 46 дугаар зарлиг, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”, Монгол бичгийн цуврал хичээл, монгол бичгийн гарын драйвер болон фонт суулгах заавар, монгол бичгээр хэрэглээний программ бичих заавар зэргийг байршуулсан. |

3.5. Сайдын тушаалын биелэлт:

Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар тус газарт үүрэг өгсөн 71 арга хэмжээ 2022 оны эхний хагас жилийн байдлаар хяналтад байгаагаас “бүрэн хэрэгжсэн” 100%-тай 41, “хэрэгжих шатанд” буюу 70%-тай 19, “хэрэгжилт хангалтгүй” буюу 30%-тай 7, “хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” 4 арга хэмжээ байгаа ба хэрэгжилт **84.2%**-тай байна.

| Нийт заалт | Үүнээс хэрэгжилтийн байдал /хувиар/ | | | | | Хүчингүй болсон | Биелэлт /хувиар/ |
|------------|-------------------------------------|----|----|---|------------------|-----------------|------------------|
| | 100 | 70 | 30 | 0 | Хугацаа болоогүй | | |
| 71 | 41 | 19 | 7 | - | 4 | - | 84.2 |

“Хэрэгжилт хангалтгүй” 30%-тай 7 арга хэмжээ:

1. Төлөвлөгөө батлах тухай 2016.06.27 №174. 2/Энэхүү төлөвлөгөөний биелэлтийг тухайн салбарын түвшинд зохион байгуулж, чиг үүргийн дагуу туссан арга хэмжээ, гүйцэтгэлийн үр дүнг улирал тутам яаманд тайлагнаж байхыг харьяа агентлаг, байгууллагын

удирдлагуудад үүрэг болгосугай. /Зам, тээврийн салбарын хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө 2016-2022/;

Биелэлт: Зам, тээврийн салбарын хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөнд "Автомтээврийн үндэсний төв"-өөс хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн 2021.09.20-ны өдрийн 1/1149, 2021.11.23-ны өдрийн 1/1467 тоот албан бичгээр тус тус ЗТХЯ-нд хүргүүлсэн.

2. Тушаалын хэрэгжилтийг сайжруулах зарим арга хэмжээний тухай 2020.10.29 №А/202 1.Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны "Сахилга хариуцлага-хөдөлмөрийн аюулгүй байдлын жил болгон зарлах тухай" А/01 дугаар тушаалын хэрэгжилтийг шалгах ажлын удирдамжийн дагуу хийгдсэн шалгалтын дүнг хавсралтад дурдсанаар үнэлсүгэй. 3. Илэрсэн зөрчлийг арилгасан тухай тайланг 2020.11.20-ны дотор ХШҮДАГ-т ирүүлэх, цаашид сахилга, хариуцлага, хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр хяналт шалгалтыг харьяа байгууллага бүр дотооддоо зохион байгуулж байхыг холбогдох байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

Биелэлт: Орхон аймгийн автоматтээврийн төвийн автобуудлын барилгын ажлыг тус аймгийн орон нутгийн санхүүжилтээр 2022-2023 онд барьж байгуулахаар төлөвлөж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг цахим хэлбэрээр 2022.01.18-ны өдөр зарлаж, 2022.02.18-ны өдөр нээсэн. Тендерт "Шинжүү" ХХК шалгарсан бөгөөд гүйцэтгэлийн шатандаа явж байна.

3.Төлөвлөгөө батлах тухай 2021.02.09А/19. 3.4.6.Баян-Өлгий, Увс, Ховд, Өвөрхангай, Архангай, Баянхонгор, Өмнөговь, Дорнод, Завхан аймгуудад аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлж, отоглох цэг, авто зам дагуу үйлчилгээний цогцолборуудыг байгуулна. Говийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

Биелэлт: 2022.06.06-ны өдрийн байдлаар:Автобуудлын стандарт шаардлага хангахгүй байгаа Булган, Орхон, Говьсүмбэр, Сэлэнгэ, Дорнод, Өвөрхангай, Сүхбаатар, Дундговь, Замын-Үүд, Ховд зэрэг 10 аймагт стандартын шаардлага хангасан автобуудал байгуулах зорилгоор өнөөгийн нөхцөл байдал, зорчигч эргэлт болон ачааллыг харгалзан цаашдын төлвийн төсөөллийг боловсруулан танилцуулгыг бэлтгэн ЗТХЯ-ны АТБХЗГ-ын мэргэжилтэн Ж.Нарантунгалагт хүргүүлсэн.

4.Хот хоорондын зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2021.04.27 №А/63

1.4/ Зорчигч тээврийн үйлчилгээнд ашиглаж байгаа автобусыг техникийн хяналтын үзлэгт хамруулж байгаа асуудлаар тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдээс ирж буй гомдлыг судлан үзэж уг ажлыг хууль эрх зүйн хүрээнд зохион байгуулах, инженер, техникийн ажилтнуудыг авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлд хяналтын тогтолцоо бүрдүүлэх.

Биелэлт: 2021.10.15-ны өдөр Авлига ашиг сонирхлоос ангид байх, авлигын хор уршиг, хүлээх үүргийн талаарх сургалтанд тээврийн хэрэгслийн бүртгэлийн хэлтсийн мэргэжилтнүүд, Автомтээврийн хяналтын мэргэжилтнүүд, техникийн хяналтын үзлэгийн инженер, техникч, тээвэр зохицуулагч, ахлах мэргэжилтнүүд тус тус хамрагдсан.

1.5/ Зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хийх хяналт, шалгалтыг цар тахлын үеийн нөхцөл байдалтай уялдуулан зөвлөн, туслах үйлчилгээнд шилжүүлэх, төрийн зүгээс үзүүлэх үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, цахимжуулах талаар холбогдох арга хэмжээ авах;

Биелэлт: УОК-ын даргын 46 дугаар "Түр журам"-ын хүрээнд Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, хууль бус тээвэрлэлтийг таслан зогсоох чиглэлээр Тээврийн цагдаагийн алба, Автомтээврийн үндэсний төвийн хяналтын тасгийн АТХУБ, СХЗТТ, БЗЗТТ, Лавай автобуудалтай хамтарсан хяналт шалгалтыг 2021.05.22-2021.06.01-ний өдрүүдэд зохион

байгуулсан. Хяналт шалгалтанд 27 аж ахуйн нэгж байгууллага хамрагдсан бөгөөд /Ковид-19/-ын үеийн нөхцөл байдалтай уялдуулан 68 жолоочид зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн.

Нийтийн тээврийн үйлчилгээнд оролцож буй тээврийн хэрэгслүүдэд автотээврийн хяналтын улсын байцаагч нар холбогдох стандарт болон замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлага хангаж буй эсэхэд тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Ковид-19 -ийн "Халдвараас сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах" ажлын хүрээнд Зорчигч тээврийн төвүүдээр дамжуулан тээвэрлэлт эхлэхийн өмнө болон дууссаны дараа нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгслүүдэд ариутгал халдваргүйжилтийг "Өнө Мөнх Тэнгэр" ХХК-аар нийт 780 /давхардсан тоогоор/ тээврийн хэрэгсэлд ариутгалыг хийсэн.

1.7/ Улс, хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээний тасалбар олгох үйлчилгээг төрийн бус байгууллагад шилжүүлэх талаар Төрийн бус байгууллагуудаас ирүүлсэн саналыг судлан үзэж холбогдох тооцоо, судалгааг хийж танилцуулах.

Биелэлт: Улс, хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээний тасалбар олгох үйлчилгээг төрийн бус байгууллагад шилжүүлэх талаар Төрийн бус байгууллагуудаас ирүүлсэн саналыг судалж тооцоо судалгааг хийж байна.

1.8/ Зорчигч тээврийн үйлчилгээний жолооч нарын хөдөлмөр, амралтын горимыг мөрдүүлэх чиглэлд аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж, хяналтыг сайжруулах;

Биелэлт: 2021.03.11-2021.03.26-ны өдрийн хооронд орон нутгийн автотээврийн 21 төв, 4 салбарын дарга, хот хоорондын нийтийн тээврийн 41 аж ахуйн нэгж байгууллагын 115 ажилтанд жолоочийн хөдөлмөр, амралтын горимын талаарх нарийн мэдлэг олгох сургалтыг шат дараатайгаар зохион байгуулсан.

-2021.05.27-2021.05.29-ны өдрийн хооронд Өмнөговь аймгийн автотээврийн төв, Цогтцэций салбарын 42 ажилтнуудад Улс, хот хооронд болон орон нутгийн нийтийн тээврийн зохион байгуулалт, тээврийн нэгдсэн систем, зорчигч тээврийн бүртгэлийн системийн ашиглалт, жолоочийн хөдөлмөр, амралтын горим, MNS 5012:2011 стандартын шинэчилсэн төслийн танилцуулга, ХАБЭА-ын талаарх мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан.

Мөн Улс, хот хоорондын зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээг зохион байгуулах талаар холбогдох, хууль эрх зүйн мэдлэг олгох, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, цаашид хийгдэх ажлын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

Хөвсгөл, Булган, Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ аймгуудад томилолтоор ажиллан орон нутгийн аж ахуйн нэгж байгууллагуудын удирдлага болон жолооч нарт хөдөлмөр амралтын горимын талаарх мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан. УОК-ын даргын 46 дугаар "Түр журам"-ын хүрээнд Зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг цар тахлын үеийн нөхцөл байдалд уялдуулан хийх ажлын хүрээнд 27 аж ахуйн нэгж 68 жолоочид зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.

-2021.04.02-ны өдөр Тээврийн цагдаагийн албатай хамтран "Хот хоорондын нийтийн тээвэрлэлт гүйцэтгэж байхдаа анхаарах асуудлууд" сэдэвт сургалтыг хот хоорондын нийтийн тээврийн аж ахуйн нэгж байгууллагуудын инженер техникийн ажилтан, жолооч нарыг хамруулан сургалт зохион байгуулсан. Сургалтад 41 аж ахуйн нэгж байгууллагын 115 ажилтан хамрагдсан.

-2021.06.04-ний өдөр Зорчигч тээврийн төвүүдэд шинээр ажилд орсон тээвэр зохицуулагч нарт Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/24 дугаар тушаал, Хөдөлмөр, амралтын горим, MNS 5012:2011 стандарт болон, Улс, хот хоорондын нийтийн зорчигч тээвэрлэлтийн зохион байгуулалт, гэрээ, болон тээвэр зохицуулагчийн ажлын байрны тодорхойлолтыг танилцуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгсөн.

-2021.06.24-ний өдөр Хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын удирдлага, тээвэр зохицуулагч, ажилтан, жолооч нарын ур чадварыг нэмэгдүүлэх, ХАБЭА-ын сургалтын хэрэгцээг тодорхойлох 23 асуулыг боловсруулан нийт 62 ААНБ-ын бүртгэлтэй цахим хаяг-нд хүргүүлсэн.

-2021.11.01-2021.11.05-ний өдрүүдэд "Цаглашгүй мэдлэг" ТББ, НЭМҮТ, ТЦА, АТҮТ хамтран танхим, цахимаар Улс, Хот хоорондын нийтийн тээврийн жолооч нарт "Халдварт, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх", "Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх арга зам", "Жолоочийн хөдөлмөр амралтын горим, түүний хэрэгжилт", "Зорчигч

тээвэрлэлтийн аюулгүй байдал, "Зам тээврийн осол саатлаас урьдчилан сэргийлэх" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд нийт 618 жолооч хамрагдсан.

Тайлант хугацаанд Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар тус газарт үүрэг өгөөгүй байна.

3.6. Сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрийн биелэлт:

Сайдын зөвлөлийн хуралдааны 2021 оны шийдвэрээс тус газрын хариуцан хэрэгжүүлэх 1 арга хэмжээ 2022 оны эхний хагас жилийн байдлаар хяналтад байгаа ба "хэрэгжих шатанд" буюу 70%-тай байна.

3.7. Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллахаар байгуулсан "Санамж бичиг"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт:

Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллахаар байгуулсан "Санамж бичиг"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тус газраас хариуцан хэрэгжүүлэх 4 арга хэмжээ байгаагаас "үр дүнтэй" буюу 100%-тай 1, "тодорхой үр дүнд хүрсэн" буюу 90%-тай 1, "үр дүнгүй" буюу 30%-тай 2 арга хэмжээ байгаа ба хэрэгжилтийн дундаж 62.5%-тай байна.

| Нийт арга хэмжээ | Хэрэгжилт / хувиар / | | | | | | | Биелэлт /Хувиар/ |
|------------------|----------------------|----|----|----|----|---|------------------|------------------|
| | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | Хугацаа болоогүй | |
| 4 | 1 | 1 | - | - | 2 | - | - | 62.5 |

"Үр дүнгүй" буюу 30%-тай 2 арга хэмжээ:

1. Нийслэлд зорчигч тээврийн терминал байгуулна. /2.5/ **Зорилт:** 2021 онд: ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлүүлнэ.

Биелэлт: Коронавируст халдвар COVID-19 цар тахлын нөлөөгөөр Монгол Улсын Засгийн газрын 2021.02.17-ны өдрийн 43 дугаар тогтоол, ТӨБЗГ-ын 2021.02.26-ны өдрийн А-1/354 дүгээр албан даалгааврын дагуу ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах боломжгүй болсон.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нийслэлд зорчигч тээврийн зориулалт бүхий терминалуудыг байгуулна" гэж тусгагдсаны дагуу "Концессын тухай хууль"-ийн 10.3 дахь заалтын дагуу Улаанбаатар хотын Хан-Уул, Баянзүрх дүүрэгт байгуулагдах автобуудлын нөхцөл байдал, үр ашгийн тооцооллыг хийн 2021.10.29-ний өдрийн 2/1378 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.

2. Авто үйлчилгээний салбараас үүсэж буй хог хаягдлыг авто үйлчилгээ эрхлэгчдээс боловсруулах үйлдвэр хүртэлх тээвэрлэлтийн нэгдсэн сүлжээ бий болгох /5.2/ **Зорилт:** 2021 онд авто үйлчилгээний байгууллагын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэлтийн схем, зураг, төсөв боловсруулах, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх.2022-2024 онд авто үйлчилгээний салбараас үүсэж буй хог хаягдлыг авто үйлчилгээ эрхлэгчдээс боловсруулах үйлдвэр хүртэлх тээвэрлэлтийн нэгдсэн сүлжээ бий болно.

Биелэлт: Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй авто үйлчилгээний байгууллага, уул уурхай, ашигт малтмал, хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамруулан тэдгээрийн ажил үйлчилгээний явцад үүссэн аюултай хог

хаягдлыг судалгааг гарган, санал боловсруулан 2021.06.02-ны өдрийн 2/690 тоот албан бичгээр ЗТХЯ-ны АТБХЗГ-т хүргүүлсэн.

3.8. Ил тод, нээлттэй байдлын үнэлгээ:

Нийтийн мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг үнэлэх 46 шалгуур үзүүлэлтийн 29 шалгуур үзүүлэлт нь тус газарт хамааралтай бөгөөд үүнээс "бүрэн хэрэгжсэн" буюу 100%-тай 19, "хэрэгжих шатанд" буюу 70%-тай 7, "хэрэгжилт хангалтгүй" буюу 30%-тай 2, хэрэгжээгүй буюу 0%-тай 1 арга хэмжээ байгаа ба хэрэгжилт **84.5%**-тай байна.

| Шалгуур үзүүлэлтийн тоо | Үүнээс хэрэгжилтийн байдал | | | | Биелэлт / хувиар / |
|-------------------------|----------------------------|----|----|---|--------------------|
| | 100 | 70 | 30 | 0 | |
| 29 | 19 | 7 | 2 | 1 | 84.5 |

Хэрэгжилт хангалтгүй" буюу 30%-тай 2 арга хэмжээ:

1. Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт / 3.11/

Биелэлт: 2022.03.23-ны өдрөөс 04.01-ний өдрийг дуустал "Мэргэшсэн жолоочийн сургалтын тасаг"-т , 2022.05.03-наас 05.05-ны өдрийг дуустал" Сонгинохайрхан зорчигч тээврийн төв"-д , 2022.06.06-наас 06.08-ны өдрийг дуустал "Сонгинохайрхан техникийн хяналтын үзлэгийн төв"-үүдэд үйлдвэрийн газрын захирлын баталсан удирдамжийн дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус санхүүгийн аудит бусад хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн тайланг танилцуулж, зөвлөмж зөвлөгөө өгч ажиллалаа. Мөн цаашид ХШДАА-ны төлөвлөгөөний дагуу үйлдвэрийн газрын худалдан авах ажиллагаа болон бусад үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж ажиллана.

2. Хууль тогтоомжид заасан бусад. / 3.15/

Биелэлт: "АТҮТ" ТӨҮГ, ТӨБЗГ-тай байгуулсан контактын гэрээний биелэлтийг хангуулах зорилгоор 2017 оноос хойш үйлдвэрийн газрын ажилтан болон үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг жилд 1 удаа авч байна. 2022 оны судалгаанд орон нутаг болоод нийслэлийн 38 салбар нэгжийн 336 ажилтан, албан хаагч хамрагдсан. Судалгаанд хамрагдсан ажилчид үйлдвэрийн газрын захирлын удирдах арга барил, үр чадварт нь 249 ажилтан буюу 74% нь сайн, үлгэр дуурайлал манлайлалд 235 ажилтан буюу 70% нь сайн, заавар зөвлөгөө өгөх, сонсох үр чадварт дийлэнх хувь буюу 73% сайн гэсэн үнэлгээ өгсөн байна.

АТҮТ" ТӨҮГ-аар үйлчлүүлж буй нийт 350 үйлчлүүлэгчээс сэтгэл ханамжийн судалгаа авсан. Нийт үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн индекс дундаас дээгүүр (7.26-8.08) байна. Иймд бид үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг жилд нэг удаа бус тогтмол хийж хангалтгүй үнэлгээ авсан үйл ажиллагааны чиглэлээр тухай бүр тодорхой ажил сайжруулах төлөвлөгөө гарган үйлчилгээний чанарыг байнга сайжруулж ажиллах шаардлагатай байна.

"Хэрэгжээгүй" тасарсан 1 арга хэмжээ:

1. Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам./2.2/

Биелэлт: Автотээврийн үндэсний төвийн ажилчдын мэргэжил, үр чадварын түвшин тогтоох журмыг Хууль, эрх зүйн цэсний Дүрэм ,журам дэд цэсэд байршуулсан. /хамааралгүй/

3.9. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ нь тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн веб сайтад төсөв, гүйцэтгэлийн чиглэлээр 7, хөрөнгө оруулалт, худалдан авалт, тендэрийн

чиглэлээр 5, бусад чиглэлээр 6, нийт 3 чиглэлийн хүрээнд 18 төрлийн мэдээ байршуулахаас 13 төрлийн мэдээг цаг хугацаанд нь, 3 төрлийн мэдээг хугацаа хоцроож байршуулсан, 5 мэдээллийн байршуулах хугацаа болоогүй байгаа ба хэрэгжилт 93.0%-тай байна.

| № | Мэдээллийн агуулга | Байршуулбал зохих мэдээллийн | Байршуулсан мэдээллийн төрөл | Хугацаа хоцроож байршуулсан | | | | | Биелэлт /хувиар/ |
|----|--|---------------------------------|---------------------------------|-------------------------------|-----|----|----|---|------------------|
| | | | | Тайлант хугацаанд байршуулсан | 100 | 70 | 30 | 0 | |
| 1. | Төсөв, гүйцэтгэл | 7 | 3 | 2 | 1 | - | - | 4 | 90.0 |
| 2. | Хөрөнгө оруулалт, тендэр, худалдан авалт | 5 | 4 | 4 | - | - | - | 1 | 100 |
| 3. | Бусад | 6 | 6 | 4 | 2 | - | - | - | 90.0 |
| | Дүн | 18 | 13 | 10 | 3 | - | - | 5 | 93.0 |

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын үйл ажиллагаанд 2022 оны эхний хагас жилийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн дүнг хүснэгтээр харуулбал:

| № | Хяналтанд байх арга хэмжээ | 2022 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ | Үүнээс | | Дундаж хувь | Биелэлт /Хувиар/ | | | | | |
|---|---|--------------------------------------|---------------------------------------|-------------------------------------|-------------|------------------|----|----|----|----|---|
| | | | Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ | Тухайн улиралд тасарсан арга хэмжээ | | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 |
| 1 | “Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ”-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт | 72 | 69 | - | 71.0 | 15 | 3 | 36 | 8 | 7 | - |
| 2 | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | 4 | 4 | - | 62.5 | 1 | - | 1 | 1 | 1 | - |
| 3 | МУ-ын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний биелэлт | 1 | 1 | 1 | 0.0 | - | - | - | - | - | 1 |
| 4 | Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлт | 4 | 4 | - | 67.5 | 1 | - | 2 | - | 1 | - |
| 5 | Сайдын тушаалын биелэлт | 71 | 67 | | 84.2 | 41 | - | 19 | - | 7 | - |
| 6 | Сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрийн биелэлт | 1 | 1 | - | 70.0 | - | - | 1 | - | - | - |
| 7 | ЗТХСайд, Нийслэлийн ЗД-тай байгуулсан “Санамж бичиг”-ийн биелэлт | 4 | 4 | - | 62.5 | 1 | 1 | - | - | 2 | - |
| 8 | Ил тод нээлттэй байдлын үнэлгээ | 29 | 29 | 1 | 84.5 | 19 | - | 7 | - | 2 | 1 |
| 9 | Шилэн дансны хөтөлөлтийн үнэлгээ | 18 | 13 | - | 93.0 | 10 | - | 3 | - | - | - |

| | | | | | | | | | | |
|-----|-----|-----|---|------|----|---|----|---|----|---|
| Дүн | 204 | 192 | 2 | 78.3 | 88 | 4 | 69 | 9 | 20 | 2 |
|-----|-----|-----|---|------|----|---|----|---|----|---|

Дөрөв. Дүгнэлт

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ нь 2022 онд Зам, тээврийн хөгжлийн яамтай "Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ"-г байгуулаагүй, гэрээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулаагүй байна. Гэсэн хэдий ч тус газрын үйл ажиллагааг "Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ"-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын Хөгжлийн 2022 оны төлөвлөгөө, Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Сайдын тушаал, Сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрийн биелэлт, Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллахаар байгуулсан "Санамж бичиг"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлт, Шилэн дансны хөтлөлт гэсэн 9 үзүүлэлтээр дүгнэлээ.

Дээрх 9 үзүүлэлтийн хүрээнд нийт 204 арга хэмжээ төлөвлөснөөс "үр дүнтэй" буюу бүрэн хэрэгжсэн 88, "тодорхой үр дүнд хүрсэн" буюу 90%-тай 4, "хэрэгжих шатанд" буюу 70%-тай 69, хэрэгжилт хангалтгүй, "эрчимжүүлэх шаардлагатай" 50%-тай 9, "хэрэгжилт хангалтгүй" 30%-тай 20, "үр дүнгүй" буюу хэрэгжээгүй тасарсан 2, хэрэгжилтийн хугацаа тооцох болоогүй 12 арга хэмжээ байгаа ба дундаж үнэлгээ 78.3%-тай байна.

Тус газрын үйл ажиллагааг 2022 оны эхний хагас жилийн байдлаар үнэлэхэд "Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ"-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 71.0%-тай, МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 62.5%-тай, МУ-ын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний биелэлт 0%-тай, Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлт 67.5%-тай, сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт 84.2%-тай, сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрийн биелэлт 70%-тай, Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга нарын хооронд байгуулсан санамж бичгийн биелэлт 62.5%-тай, Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийн үнэлгээ 84.5%-тай, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ 93.0%-тай байна.

"Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ"-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд 72 арга хэмжээ тусгаснаас 76.4% буюу 55 арга хэмжээ нь гэрээний үндсэн дээр чиг үүрэг шилжсэн 7 ажил, үйлчилгээ байна. Үүнд:

-Улс хоорондын ачаа, зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээг зохион байгуулах чиглэлээр 34;

-Жуулчин тээвэрлэлтийн үйлчилгээг зохион байгуулах чиглэлээр 1;

-Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр 11;

-Автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажлыг зохион байгуулах чиглэлээр 5;

-Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох ажлыг зохион байгуулах чиглэлээр 2;

-Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох үйл ажиллагааг аймаг, орон нутагт зохион байгуулах чиглэлээр 2 арга хэмжээ байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 01, А/125, 2021 оны 02, 07 дугаар албан даалгавраар тус газарт нийт 64 үүрэг даалгавар өгснөөс "бүрэн хэрэгжсэн" буюу 100% -тай 40, "хэрэгжих шатанд" буюу 70%-ийн хэрэгжилттэй 21, "хэрэгжилт хангалтгүй" буюу 30%-тай 3 арга хэмжээ байгаа ба Сайдын 4 албан даалгаврын хэрэгжилтийн дундаж 92.7%-тай байна.

Сайдын албан даалгаврын биелэлтийг сайдын шуурхай хуралдаанд 14 хоног тутамд танилцуулж байгаа тул үнэлгээнд оруулаагүй.

Зам, тээврийн хөгжлийн сайдын шуурхай хуралдаанаас 2022 оны эхний хагас жилд тус газарт 30 үүрэг, даалгавар өгснөөс бүрэн хэрэгжсэн 100%-тай 27, хэрэгжих шатанд буюу 70%-тай 3 үүрэг байгаа ба сайдын шуурхайн биелэлт 97%-тай байна.

Зам, тээврийн хөгжлийн яамнаас тус үйлдвэрийн газарт 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт 138 албан бичиг хүргүүлснээс хариутай 95 албан бичиг байгаа ба 86 албан бичгийн хариуг хугацаанд нь ирүүлсэн, 9 албан бичиг шийдвэрлэх шатанд байна. "АТҮТ" ТӨҮГ-аас 2022 оны эхний хагас жилд тус яаманд 124 албан бичиг ирүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 11-11 төвд тус газартай холбоотой 82 санал, хүсэлт, гомдол ирснээс 69 санал, хүсэлт, гомдолд хариу өгсөн, 13 санал, хүсэлт, гомдол хяналтад байна.

Тус газраас ирүүлсэн зарим арга хэмжээний биелэлтийг харахад төлөвлөсөн арга хэмжээний хүрэх үр дүн, дэвшүүлсэн зорилтод хамааралгүй биелэлт ирүүлж байна. Жишээ нь:

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгасан "Олон улс, улсын чанартай авто замын дагуу түр зогсох талбайг 100 км тутамд барьж байгуулах ажлыг эхлүүлэх" /3.4.4. МУТЖҮЧ-8.1.3, ЗГҮАХ-3.4.6 арга хэмжээ:

Биелэлт: Улсын чанартай авто замын дагуу хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд: Багануур дүүрэгт "Минимакс цогцолбор", Ховд аймгийн Дарви сумын нутаг дэвсгэрт "Бумбат цогцолбор", "Алфариуд" ХХК нь Төв аймгийн Баян сумын нутагт өөрийн хөрөнгөөр авто замын дагуу үйлчилгээний цогцолбор, "Нутаг хүнс трейд" ХХК нь Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутаг дэвсгэрт үйлчилгээний цогцолбор, нийт 4 цогцолбор ашиглалтад оруулсан.

"Заяын өгөөж" ХХК Архангай аймгийн Цэнхэр сумд, "Драгон" холдинг Увс аймгийн Зүүнхангай сумд, "Исун мод тур" ХХК Хэнтий аймгийн Жаргалтхаан сумд, "Баян дойт" ХХК Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумд үйлчилгээний цогцолбор байгуулах санал, ТЭЗҮ ирүүлснийг хэрэгжих боломжтой гэж үзэн хамтран ажиллах гэрээ байгуулсан.

"Бүрд чандмань" ХХК-иас Хэнтий аймгийн Хэрлэн сумд замын дагуух цогцолбор, автобуудал, мөн "Гээгт" ЗГБХН-ээс Говьсүмбэр аймгийн төвд одоогоор үйл ажиллагаа явуулж байгаа байранд өргөтгөл хийж замын дагуух цогцолбор, автобуудал байгуулах санал ирүүлээд байна." гэж тайлагнасан байна.

Тус газрын 2022 оны эдийн засаг, нийгэм, хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой, аюулгүй ажиллагаатай холбоотой болон үндсэн үйл ажиллагаатай холбоотой шалгуур үзүүлэлтийн төлөвлөгөөг яамнаас боловсруулж хүргүүлсний дагуу "АТҮТ" ТӨҮГ-аас шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийг 2022 оны эхний хагас жилийн байдлаар гаргасан байна. Үүнд:

Эдийн засгийн үзүүлэлтэд 14 үйл ажиллагаа тусгаснаас 6, нийгмийн үзүүлэлтэд 11 үйл ажиллагаа тусгаснаас 10, хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой үзүүлэлтэд 5 үйл ажиллагаа тусгаснаас 5, аюулгүй ажиллагаатай холбоотой үзүүлэлтэд 8 үйл ажиллагаа тусгаснаас 6, үндсэн үйл ажиллагаатай холбоотой үзүүлэлтэд 27 үйл ажиллагаа тусгаснаас 20 арга хэмжээ дэвшүүлсэн зорилтод хүрсэн байна.

Тав. Санал, зөвлөмж

1. "Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх 2022 оны гэрээ"-г яаралтай байгуулах, гэрээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулах;

2. "Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ", түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын Хөгжлийн 2022 оны төлөвлөгөө, Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Сайдын тушаал, Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын зам, тээврийн салбарт 2021-2024 онд хамтран ажиллахаар байгуулсан "Санамж бичиг"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтээс "эрчимжүүлэх шаардлагатай" 9, "үр дүнгүй" 20, "хэрэгжээгүй тасарсан" 2 арга хэмжээг дэвшүүлсэн зорилтод хүргэхэд анхаарч ажиллах;

3. "Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд автотээврийн чиглэлээр тусгагдсан ажлуудын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарах;

4. Дотоодын ачаа тээврийг бүртгэлжүүлэх, програм хангамжийг улсын хэмжээнд нэвтрүүлэх, хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх;

5. Нийтийн мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангах хүрээнд "Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам"-ыг яаралтай боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах;

6. "Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх дүрэм"-ийн хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлэх;

7. Эдийн засаг, нийгэм, хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой, аюулгүй ажиллагаатай холбоотой болон үндсэн үйл ажиллагаатай холбоотой 2022 оны шалгуур үзүүлэлтийг дэвшүүлсэн зорилтод хүргэхэд анхаарах.

8. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн дүгнэлт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна.

Тус газрын 2022 оны "Ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээ"-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт болон эдийн засаг, нийгэм, хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой, аюулгүй ажиллагаатай холбоотой болон үндсэн үйл ажиллагаатай холбоотой шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийг 2022 оны эхний хагас жилийн байдлаар ирүүлснийг тус тус хавсаргав.

ТАНИЛЦСАН:

САЙД



Л.ХАЛТАР

ДЭД САЙД



Ж.БАТ-ЭРДЭНЭ

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



С.БАТБОЛД

"АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ



Б.ГҮРСОРОНЗОН


АВТОТЭЭВРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА



Ё.ЖАРГАЛСАЙХАН

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДЭТЭЭЛ
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА



М.ЭНХБОЛД

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

АВТОТЭЭВРИЙН САЛБАРЫН БОДЛОГО,
ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ



О.НЯМХҮҮ

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНААС "АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨҮГ-ТАЙ
БАЙГУУЛСАН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭГ ХАРИУЦУУЛАН ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2022.06.15

Улаанбаатар хот

| Гэрээнд заасан чиглэлүүд | | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Төсөв /сая.төг/ | Хариуцах нэгж | Биелэлт | ХШҮ |
|--------------------------|---|---|-----------------|---------------|---|-----|
| № | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1.1 | <p>Автотээврийн салбарын хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, үүрэг даалгавар, хөгжлийн бодлогын баримт бичиг, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр болон салбарын сайдаас гаргасан тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангах;</p> | <p>1.1.1 Дээд газрын тогтоол шийдвэр, салбарын яамнаас гаргасан тушаал, шийдвэр, яамны удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, тайлагнах Шалгуур үзүүлэлт: Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Үүрэг даалгаврын хэрэгжилт 70-аас доошгүй хувь хангагдсан байна.</p> | - | ЗСХНХ | <p>Монгол улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, албан даалгавраар тус үйлдвэрийн газар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг 2022 оны 1-р улирлын байдлаар гаргаж, 2022.03.22-ний өдрийн 1/365, эхний хагас жилийн байдлаар 2022.06.07-ний өдрийн 1/772 тоот албан бичгээр тус тус хүргүүлж, тайлагнасан. ЗТХЯ-ны ХШҮДАГ-аас 2022.05.04-ний өдрийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 5 заалт хяналтад байгаагаас 100% хэрэгжсэн 2, 70%-3 ажил, үнэлгээний дунджаар 82 %-тай дүгнэсэн байна. Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар тус үйлдвэрийн газарт өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг гаргаж, 2022 оны 1-р улирлын байдлаар 2022.03.24-ны өдрийн 1/380, эхний хагас жилийн байдлаар 2022.06.08-ний өдрийн 1/781 тоот албан бичгээр тус тус ЗТХЯ-ны ХШҮДАГ-т хүргүүлж, тайлагнасан. ЗТХЯ-ны ХШҮДАГ-аас 2022.05.04-ний өдрийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 69 заалт хяналтад байгаагаас 100% хэрэгжсэн 39, 70%-21, 30%-4, хугацаа болоогүй-4, хүчингүй болсон-1 ажил, үнэлгээний дунджаар 85,7 %-тай дүгнэсэн байна. Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн хуралдаанаас тус үйлдвэрийн газарт өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 2022.03.28-ны өдрийн 1/394 тоот албан бичгээр хүргүүлж, тайлагнасан. Эхний хагас жилийн байдлаар 2022.06.15-ний өдрийн 1/807 тоот албан бичгээр ЗТХЯ-ны ХШҮДАГ-т хүргүүлж, хэрэгжилт, үр дүнг тайлагнасан. ЗТХЯ-ны Сайдын зөвлөлийн 3 удаагийн хуралдаанаас тус үйлдвэрийн газарт өгсөн 4 үүрэг хяналтад байсан бөгөөд ХШҮДАГ-аас 2022</p> | 100 |

| | | | | | | |
|--|--|--|---|--|--|-----|
| | | | | оны 1-р улиралд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 3 үүргийг 100% хэрэгжсэнд тооцож, хяналтаас хассан бөгөөд 1 үүрэг даалгавар 70%-ийн хэрэгжилттэй байна. Дээрх тогтоол шийдвэрийн хэрэгжилт 2022 оны эхний хагас жилийн байдлаар дунджаар 79,2%-тай зорилтот түвшиндээ хүрсэн байна. | | |
| | | 1.1.2 "Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр"-т тусгагдсан Автотээврийн үндэсний төвөөс хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, улирал бүр яаманд тайлагнах Шалгуур үзүүлэлт: Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: 2022 оны ажлуудын биелэлт 70-аас доошгүй хувь хангагдсан байна. | - | ЗСХНХ | "Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний төлөвлөгөө"-ний биелэлтийг нэгтгэн гаргаж, ЗТХЯ-нд 2022 оны 1-р улирлын байдлаар 2022.03.24-ны өдрийн 1/379, эхний хагас жилийн байдлаар 2022.06.13-ний өдрийн 1/791 тоот албан бичгээр хүргүүлж, хэрэгжилт, үр дүнг тайлагнасан. Тус хөтөлбөрт үйлдвэрийн газраас хэрэгжүүлэхээр нийт 14 ажил хяналтад байгаагаас бүрэн хэрэгжсэн 100%-3, 70%-тай 4, 30%-тай 7 ажил байна. Дунджаар 56,4 хувийн хэрэгжилттэй байна. | 50 |
| | | 1.1.3 Зам, тээврийн хөгжлийн сайдын албан даалгавруудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, улирал бүр яаманд тайлагнах Шалгуур үзүүлэлт: Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Үүрэг даалгаврын хэрэгжилт 70-аас доошгүй хувь хангагдсан байна. | | ЗСХНХ | Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 01 дүгээр албан даалгавраар тус үйлдвэрийн газарт өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг 2022 оны эхний хагас жилийн байдлаар гаргаж, ЗТХЯ-ны ХШУДАГ-т 2022.06.13-ны өдрийн 1/797 тоот албан бичгээр хүргүүлж, тайлагнасан. Мөн сайдын 2020 оны А/125, 2021 оны 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг гаргаж, ЗТХЯ-ны ХШУДАГ-т 2022.06.13-ний өдрийн 1/798 тоот албан бичгээр хүргүүлж, хэрэгжилт, үр дүнг тайлагнасан. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021.09.15-ны өдрийн 07 дугаар албан даалгавраар тус үйлдвэрийн газарт өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг 2022 оны 1-р улирлын байдлаар гаргаж, ЗТХЯ-ны ХШУДАГ-т 2022.03.22-ны өдрийн 1/366, 2022.06.13-ний өдрийн 1/798 тоот албан бичгээр тус тус хүргүүлж, тайлагнасан. 2022 оны эхний хагас жилийн байдлаар албан даалгавруудын хэрэгжилт 87,4 хувьтай хэрэгжиж, зорилтот түвшиндээ хүрсэн байна. | 100 |

| | | | | | | |
|--|--|---|--|--------------------|--|-----------|
| | | <p>1.1.4 Зам, тээврийн хөгжлийн сайдын "Зорчигч тээврийн үйлчилгээг сайжруулах тухай" 2020.10.22 №А/200 тушаалын хэрэгжилтийг бүрэн хангуулж тайлагнах Шалгуур үзүүлэлт: Сайдын тушаалын хэрэгжилтийн хувь Хугацаа: I-II улирал Зорилтот түвшин: Тушаал хэрэгжсэн байна.</p> | | <p>ЗТХ ХУХ</p> | <p>ЗТХ: Зам, тээврийн хөгжлийн сайдын "Зорчигч тээврийн үйлчилгээг сайжруулах тухай" 2020.10.22 №А/200 тушаалд зорчигч тээвэртэй холбоотой 2 заалт тусгагдсан. Тушаалын 1.1-д "Хот хоорондын нийтийн тээвэрлэлтийн дундын зогсолтын тарифыг тогтоон мэдээллийн санд оруулах, орон нутгийн зорчигч тээврийн тасалбарыг цахимжуулах, кассын машинаар хэвлэх, НӨАТ-ын баримт олгох ажлыг 2020.12.25 өдрийн дотор зохион байгуулах" гэж заасны дагуу үйлчилгээ үзүүлж буй 54 чиглэлийн дундын зогсоолын тарифуудыг тогтоон Зорчигч тээврийн бүртгэлийн системд бүрэн оруулж мэдээллийн санг үүсгэсэн. Мөн орон нутгийн нийтийн тээвэрлэлтийг зохион байгуулах, гүйцэтгэх гэрээ байгуулсан 55 чиглэлийг зорчигч тээврийн бүртгэлийн системд оруулан орон нутгийн зорчих тасалбарыг цахимжуулан кассын машинаар хэвлэж НӨАТ-ын баримт олгон ажиллаж байна.</p> <p>Тушаалын 1.2-т "Нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглаж байгаа их багтаамжийн автобусыг холбогдох стандарт болон замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлага хангаж буй эсэхэд хяналт тавих, тухайн тээврийн хэрэгслийн жолоочийн хажууд нэмэлт суудал суурилуулахыг зогсоох" гэж заасны дагуу улс, хот хоорондын зорчигч тээврийн автобусны жолоочийн хажуугийн нэмэгдэл суудлыг зориулалтын дагуу ашиглахгүй зорчигч суулгаж байгаа тул ААНБ -уудад тус суудлыг авах талаар АТХУБ-ийн албан шаардлагыг хүргүүлэн, жолоочийн хажуугийн нэмэгдэл суудлыг бүрэн авахуулсан.</p> <p>Тушаалын 1.3-т "Улс хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээний зорчигчдын ачаа тээш илгээмжийг хүлээн авах, хадгалах, тээвэрлэх, хүлээлгэн өгөх үйл ажиллагааг хяналт, бүртгэлд оруулан тасалбар олгох зохицуулалтыг 2020.12.25-ны өдрийн дотор зохион байгуулах гэж заасны дагуу Улсын онцгой комиссын 2021.05.19-ны өдрийн 46 дугаар тушаал, ЗТХЯ-ны 2021.05.20-ны өдрийн 07/2182 тоот албан бичгээр хот хоорондын нийтийн тээврийн хөдөлгөөнийг эхлэх болсонтой холбогдуулан 2021.05.23-ны өдрөөс эхлэн илгээмжийн ачааг хүлээн авах, түр хадгалах, бүртгэлжүүлэх ажил хийгдэж эхэлсэн.</p> <p>Ачаа тээшийг бүртгэлжүүлэх, түр хадгалах зорилгоор тус үйлдвэрийн газрын дотоод сүлжээнд /ERP/ суурилсан ачаа</p> | <p>70</p> |
|--|--|---|--|--------------------|--|-----------|

| | | | | | |
|--|--|--|---------------------|--|----|
| | | | | <p>тээшний бүртгэлийн цэсийг хөгжүүлэх ажил хийгдсэн. Дээрх ажлын хүрээнд ачаа тээш хариуцан ажиллах 21 аймгийн бүх тээвэр зохицуулагч, тээврийн мэргэжилтэн нарт ачаа тээш бүртгэлжүүлэх эрх нээсэн. 2022 оны эхний хагас жилийн байдлаар Улаанбаатар хотын 2, орон нутгийн 17 автобуудалтай салбар төвөөс 2022 оны 1 дүгээр улиралд 6 аймгийн автобуудлаар дамжуулан илгээмжийн ачаа тээшийг хүлээн авах, бүртгэлжүүлэх, түр хадгалах, хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Тушаалын 1.4-т "Осол зөрчлийн талаарх мэдээллийг шуурхай дамжуулж ажиллах тухай" Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 30 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах, мэдээллийг шуурхай дамжуулах арга хэмжээ авч ажиллаагүй албан хаагчдад тухай бүр хариуцлага тооцох гэж заасны дагуу мэдээ, мэдээллийг цаг тухай бүрт нь шуурхай дамжуулж ажиллаж байгаа бөгөөд 2022.01.01-2022.06.06-ны өдрүүдэд нийт 24.909 тээврийн хэрэгслээр 523.355 зорчигч тээвэрлэсэн бөгөөд тээврийн хэрэгслийг 24 цагийн турш хянаж, шуурхай зохицуулалтаар хангаж ажилласан. Тус хугацаанд 157 удаагийн саатал, 5 удаагийн /4 нь шүргэлцэх төрлийн осол / осолд холбогдсон тохиолдол бүртгэгдсэн. Тайлант хугацаанд хариуцлага алдсан албан хаагч байхгүй болно.</p> <p>Тушаалын 1.5-д "Холбогдох стандартын шаардлага хангасан авто замын дагуух үйлчилгээний байгууламжтай ААН-тэй гэрээ байгуулж ажиллах, сум суурин газарт зорчигчдыг буулгах, суулгах цэг/автобуудал/-ыг тодорхой болгож хяналт тавьж ажиллах, зөрчил гаргаж байгаа үйлчилгээ эрхлэгчдэд хариуцлага тооцох" гэж заасны дагуу стандартын шаардлага хангасан 1 аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд 7 хоног бүр мэдээ мэдээлэл солилцон хяналт шалгалтыг улирал тутам зохион байгуулан ажиллаж байна. Гэрээ байгуулах хүсэлт гаргасан 2 аж ахуйн нэгж байгууллагад зөвлөмж хүргүүлээд байна.</p> | |
| | 1.1.5 Зам, тээврийн хөгжлийн сайдын "Хот хоорондын зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай" 2021.04.27 №А/63 дугаар тушаалын хэрэгжилтийг бүрэн хангуулж тайлагнах | | ЗТХ ХУХ ЗСХНХ | <p>ЗТХ: Зам, тээврийн хөгжлийн сайдын "Зорчигч тээврийн үйлчилгээг сайжруулах тухай" 2020.10.22 №А/63 тушаалд зорчигч тээвэртэй холбоотой 6 заалт тусгагдсан. Хот хоорондын нийтийн тээвэрлэлтийг зохион байгуулах, гүйцэтгэх гэрээний шинэчилсэн төсөл, хот хоорондын нийтийн тээврийн үнэ, тасалбар борлуулалт болон үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр хийж</p> | 70 |

| | | | | | |
|--|---|---|-------|---|----|
| | <p>Шалгуур үзүүлэлт: Сайдын тушаалын хэрэгжилтийн хувь</p> <p>Хугацаа: I-II улирал</p> <p>Зорилтот түвшин: Тушаал хэрэгжсэн байна.</p> | | | <p>хэрэгжүүлэхээр тусгагдсан 5 заалт бүрэн хэрэгжсэн бөгөөд 100%-ийн биелэлттэй байна.</p> <p>"Зорчигч тээврийн үйлчилгээний жолооч нарын хөдөлмөр амралтын горимыг мөрдүүлэх чиглэлд аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж, хяналтыг сайжруулах" заалтын хүрээнд 2022.03.31–2022.06.03-ний өдрийг дуустал хугацаанд 16 аймгийн Автотээврийн төвийн ажилтнуудад сургалт зохион байгуулан хэрхэн хяналт тавих талаар мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгсөн.</p> <p>ХУХ: 2022 оны эхний хагас жилд зорчигч тээврийн 7361 тээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийж ажилласан байна. Нийт шалгасан тээврийн хэрэгслээс тээвэрлэлтийн гэрээгүй зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлсэн 165 тээврийн хэрэгсэлд 16.500.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан.</p> | |
| | <p>1.1.6 Үйлдвэрийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийх</p> <p>Шалгуур үзүүлэлт: Үйлдвэрийн газрын нийт салбар, төвүүдэд санхүүгийн аудит хийгдсэн байх</p> <p>Хугацаа: II-III улирал</p> <p>Зорилтот түвшин: Санхүүгийн аудит хийсэн байна.</p> | - | ХШДАА | <p>Хяналт-шинжилгээ, дотоод аудитын албаны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1.3, 1.1.4 дэх заалт, дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний 1.3, 1.6 дахь заалтуудыг үндэслэн Зорчигч тээврийн хэлтсийн Мэргэшсэн жолоочийн тасагт 2022.03.23-наас 2022.04.01-ний өдрүүдэд, Сонгинохайрхан зорчигч тээврийн төвд 2022.05.03-05-ны өдрүүдэд, Сонгинохайрхан техникийн хяналтын үзлэгийн төвд 2022.06.06-08-ний өдрүүдэд санхүүгийн аудит хийж холбогдох зөвлөмжүүдийг хугацаатай өгч ажиллаж байна.</p> | 30 |
| | <p>1.1.7 Байгууллагын дотоод хяналтыг Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "ААНБ-ын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын хүрээнд нийцүүлэн төрийн өмчийн ашиглалт, захиран зарцуулалтын байдалд дотоод хяналт шалгалтыг үр дүнтэй зохион байгуулж, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах</p> <p>Шалгуур үзүүлэлт:</p> | - | ХШДАА | <p>2022.01.05-ны өдөр Үйлдвэрийн газрын "2022 оны дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө"-г батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн Улаанбаатар хот дахь техникийн хяналтын үзлэгийн болон зорчигч тээврийн төвүүд болон орон нутгийн салбар төвүүдэд дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг батлуулан, 2022.03.20-ноор тасалбар болгон 25-нд биелэлтийг нэгтгэн авч, дүгнэлт хийж зөвлөмжийг хүргүүлэн ажилласан.</p> <p>2022 оны хагас жилийн дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний биелэлтийг 2022.06.20-ноор тасалбар болгон 25-нд нэгтгэн авч, дүгнэлт хийж, зөвлөмжийг хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.</p> <p>Мөн 2022 оны Хяналт-шинжилгээ, дотоод аудитын албаны батлагдсан төлөвлөгөө болон "Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө"-ний дагуу Мэргэшсэн жолоочийн сургалтын</p> | 70 |

| | | | | | | |
|-----|---|---|---|-------|--|----|
| | | <p>Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилт 70-аас доошгүй хувь биелсэн байна.</p> | | | <p>тасагт 2022.03.23-наас 2022.04.01-ний өдрүүдэд, Сонгинохайрхан зорчигч тээврийн төвд 2022.05.03-05-ны өдрүүдэд, Сонгинохайрхан техникийн хяналтын үзлэгийн төвд 2022.06.06-08-ний өдрүүдэд, дотоод хяналт шалгалтыг батлагдсан удирдамжийн дагуу хийж гүйцэтгэн тайлагнаж, эрсдэлээс урьдчилан сэргийлж, заавар зөвлөмж өгч ажиллалаа.</p> | |
| 1.2 | <p>Мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлэн ажиллах, ба инженер, техникийн болон тээвэр зохион байгуулалт хариуцсан ажилтнуудыг хөгжүүлэх, чадавхжуулах чиглэлээр холбогдох сургалтыг байгууллагынхаа хэмжээнд тогтмол зохион байгуулах, тээвэрлэлттэй холбоотой хууль эрх зүйн болон техникийн талаарх мэдээллийг тогтмол хүргэх, ж байх</p> | <p>1.2.1 Албан тушаалын тодорхойлолтод тавигдсан шаардлагад нийцсэн мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлэх Шалгуур үзүүлэлт: Мэргэжлийн шаардлагад нийцсэн хүнийг томилсон тоо Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Ажлын байрны мэргэжлийн шаардлагад нийцсэн хүнийг томилсон байна.</p> | - | ЗСХНХ | <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 420 дугаар тогтоолоор "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсан. Үүнд: Захирал-1, Дэд захирал-4, 1 алба, 8 хэлтэс, 4 тасаг, Улаанбаатар хот дахь Судалгаа, хөгжил, чанарын удирдлагын 1 төв, Зорчигч тээврийн 2 төв, Техникийн хяналтын үзлэгийн 3 төв, аймгийн автотээврийн 21 төв болон Замын-Үүд, Цогтцэций салбар болно. Орон тооны дээд хязгаарыг 819 ажилтан, албан хаагчтай байхаар тогтоосон бөгөөд үйлдвэрийн газрын захирлын 2022.02.09-ний өдрийн А/45, А/46 дугаар тушаалаар тус үйлдвэрийн газрын бүтцийн нэгжийн ажил, мэргэжлийн жагсаалт, орон тоог батлан захирлын Б/100-р тушаалаар үйлдвэрийн газрын нийт ажилтанг чөлөөлж, Б/101-р тушаалаар ажил, мэргэжлийн жагсаалтын дагуу ажилд томилсон. Мөн 2022.03.28-ны өдрийн А/78 дугаар тушаалаар ЗСХНХ, ЗТХ-ийн ажил, мэргэжлийн жагсаалт, орон тоог шинэчлэн батлан мөрдөж байна.</p> <p>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасны дагуу үйлдвэрийн газрын 4 дэд захирлыг үүрэгт ажлаас нь чөлөөлж, хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>2022.05.31-ний өдрийн байдлаар 1 алба, 8 хэлтэс, 4 тасаг, 1 төвд 288 орон тоо батлагдсанаас 260 ажилтан, албан хаагч, Улаанбаатар хот дахь Судалгаа, хөгжил, чанарын удирдлагын төв, Зорчигч тээврийн 2 төв, Техникийн хяналтын үзлэгийн 3 төвд 187 орон тоо батлагдсанаас 182 ажилтан, албан хаагч, аймгийн автотээврийн 21 төв, Замын-Үүд, Цогтцэций салбарт нийт 320 орон тоо батлагдсанаас 304 ажилтан, албан хаагч тус тус томилогдон ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд үйлдвэрийн газарт нийт 746 ажилтан, албан хаагч ажиллаж байна.</p> | 70 |

| | | | | | | |
|--|--|--|---|-------|---|----|
| | | <p>1.2.2 Ажилтны мэргэжил боловсролыг дээшлүүлэх, мэргэшүүлэх 2022 оны сургалтын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах</p> <p>Шалгуур үзүүлэлт: Төлөвлөгөөнд тусгагдсан сургалтын тоо</p> <p>Хугацаа: I-IV улирал</p> <p>Зорилтот түвшин: Төлөвлөгөөнд тусгагдсан 15 сургалт зохион байгуулагдсан байна.</p> | - | ЗСХНХ | <p>2022 оны эхний хагас жилийн байдлаар тус үйлдэрийн газраас төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дараахь сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 2022.03.04-ний өдөр ЗТХЯ-тай хамтран "Жендэрийн ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан хүчирхийлэл түүнээс урьдчилан сэргийлэх, эмэгтэйчүүдийн эрх зөрчигдөж буй тодорхой асуудлаар хэлэлцэх үндэсний хэмжээний цахим хэлэлцүүлэг /сургалт/-т 34 ажилтан хамрагдсан. Лавлах үйлчилгээний ажилтнуудыг чадавхижуулах, мэдээ мэдээллээр хангах сургалтыг 2022.03.05-ны өдөр зохион байгуулж, нийт 12 алба хаагч хамрагдсан. 2022.03.15-17-ны өдрүүдэд Худалдан авах ажиллагааны АЗ сертификатын цахим сургалтад 21 ажилтан хамрагдаж, 12 ажилтан шалгалт өгснөөс 6 ажилтан шалгалтад тэнцэж сертификатаа авсан. 2022.03.03-04-ний өдрүүдэд Авлигатай тэмцэх газартай хамтран "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын удирдах ажилтнууд болон аймгийн Автотээврийн төв, Замын-үүд, Цогтцэций салбарын дарга, нягтлан бодогч нарт "Авлигын гэмт хэрэг" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн кримналистик шинжилгээний газрын ахлах шинжээч Батмөнх, ахмад Пүрэвсүрэн нараар ТХБХ-ийн нийслэл орон нутгийн нийт мэргэжилтнүүдэд хуурамч бичиг баримт, тамга тэмдэг хэрхэн таних талаар сургалтыг 2022.04.20-ны өдөр цахимаар зохион явуулсан. Microsoft excel програмыг үр дүнтэй ашиглах, томъёогоор тооцооллыг автоматаар гүйцэтгэн төрөл бүрийн функц ашиглан боловсруулалт хийж сургах, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор төв болон 10 салбарын алба хаагчдад зориулсан цахим сургалтыг 2022.04.29-05.06-ны өдрүүдэд зохион байгуулсан. Үйлдвэрийн газраас 2022.05.22-ны өдөр "IMACO" сургалтын төвийн "Харилцааны ёс зүйн сургалт"-ыг зохион байгуулсан. Тус сургалтанд лавлах | 70 |
|--|--|--|---|-------|---|----|

| | | | | | | |
|--|--|--|--|--------------|---|-----|
| | | | | | <p>үйлчилгээний 13 мэргэжилтэн, 8 АТХУБ мөн ТХБХ-ийн мэргэжилтнүүд хамрагдсан.</p> <p>8. 2022.06.06,07-ний өдрүүдэд Бүтээмжийн төвтэй хамтран "Ажлын соёл 5S кайзен саналын систем"-ийн талаар ойлголт мэдээлэл өгөх сургалтыг зохион байгуулж, нийт 45 ажилтан хамрагдсан.</p> <p>9. Үйлдвэрийн газрын Мэдээллийн технологийн хэлтсээс "Тээврийн хэрэгслийн гэрчилгээг цахимжуулах нь" сэдэвт сургалт зохион байгуулж, 74 ажилтан хамрагдсан.</p> <p>10. ХАБЭА-н нийт ажилтны сургалтыг батлагдсан хөтөлбөр, хуваарийн дагуу зохион байгуулж байна.</p> <p>11. Тээвэр зохицуулагч нарын ур чадварыг нэмэгдүүлэх, ухаалаг тээврийн системийг хөгжүүлэх сургалтыг зохион байгуулж, 143 ажилтан хамрагдсан.</p> <p>12. Инженер, техникийн ажилтнуудад зориулсан 4 удаагийн сургалтыг зохион байгуулсан.</p> <p>13. Үйлдвэрийн газрын 2022 оны сургалтын төлөвлөгөөг баталж хэрэгжүүлсэн. Төлөвлөгөөнд 2022 оны эхний хагас жилд зохион байгуулахаар тусгагдсан нийт 9 сургалтаас 2022.06.20-ны байдлаар 7 сургалт зохион байгуулж, хэрэгжилт 77,7%-тай байна.</p> | |
| | | <p>1.2.3 Инженер, техникийн болон мэргэжилтэй ажилтныг мэргэшүүлэх</p> <p>Шалгуур үзүүлэлт: Сургалтанд хамрагдсан инженер, техникийн ажилтны тоо</p> <p>Хугацаа: I-IV улирал</p> <p>Зорилтот түвшин: Сургалтын хэрэгцээг тодорхойлж, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулсан байна.</p> | | ЗСХНХ ТХХ | <p>Үйлдвэрийн газраас Инженер, техникийн болон мэргэжилтэй ажилтныг мэргэшүүлэх чиглэлээр дараахь сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • 2022.01.28-ны өдөр Тээврийн хэрэгсэлтэй харьцах журам, Шударга байдал сэдэвт сургалтад нийт инженер техникийн ажилтнуудыг хамруулсан. • 2022.03.03-ны өдөр "Техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагааны итгэмжлэл" сэдвээр Улаанбаатар хотын техникийн хяналтын үзлэгийн төвүүдийн дарга, аймгуудын автотээврийн төвийн дарга нарыг тус тус сургалтанд хамруулсан. • 2022.04.28-ны өдөр "Техникийн хяналтын үзлэгийг тогтоосон дүрэм журам стандартын хүрээнд хийх, хууль бус дүгнэлт гаргахгүй байх" сэдвээр нийт инженер техникийн ажилтнуудыг сургалтанд хамруулсан. | 100 |

| | | | | | | |
|--|--|--|---|--------------|---|-----|
| | | | | | <ul style="list-style-type: none"> • 2022.05.18-ны өдөр “Тоног төхөөрөмжийн ашиглалт, арчлалт, хамгаалалт” сэдвээр нийт инженер, техникийн ажилтнуудыг сургалтанд хамруулсан. • Мэргэшсэн инженерийн зэрэг олгох мэргэшүүлэх сургалтад Сонгинохайрхан техникийн хяналтын үзлэгийн төвийн техникийн хяналтын үзлэгийн инженер Э.Мөнхсайхан, техникийн хяналтын үзлэгийн техникч Б.Цэлмэг, Говь-Алтай аймгийн Автотээврийн төвийн автотээврийн хяналтын мэргэжилтэн Д.Бат-Эрхэм, техникийн хяналтын үзлэгийн техникч Д.Бат-Ирээдүй нар хамрагдсан. • Үйлдвэрийн газрын хэмжээнд нийт 99 инженер, техникийн ажилтан байгаа бөгөөд тэдний сургалтын хэрэгцээг тодорхойлж, Монголын Автотээвэрчдийн нэгдсэн холбоотой хамтран сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан гаргаж, 2022 оны 3-р улиралд 13 инженерийг мэргэшсэн инженерийн зэрэг олгох сургалтад, Монголын Автоинженерүүдийн холбоотой хамтран 45 техникчийг мэргэшүүлэх сургалтад хамруулахаар тус тус төлөвлөн ажиллаж байна. 2022 оны эхний хагас жилийн зорилтот түвшиндээ хүрсэн болно. | |
| | | <p>1.2.4 Тээвэр зохион байгуулалт хариуцсан ажилтнуудыг хөгжүүлэх, чадавхжуулах</p> <p>Шалгуур үзүүлэлт: Автотээврийн салбарын мэргэжилтэй ажилтны эзлэх хувь</p> <p>Хугацаа: I-IV улирал</p> <p>Зорилтот түвшин: Сургалтанд 50 ажилтан хамрагдсан байна.</p> | - | ЗСХНХ ЗТХ | <p>Тээвэр зохион байгуулалт хариуцсан ажилтнуудыг хөгжүүлэх, чадавхжуулах чиглэлээр тус үйлдвэрийн газраас дараахь сургалтуудыг зохион байгуулсан.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Нийслэлийн прокурорын газар, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ, Нийтийн тээврийн газрын хамтарсан “Хяналтын мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх” сургалт зохион байгуулж 16 автотээврийн хяналтын мэргэжилтэн хамрагдсан. • Тээвэр зохицуулагчийн мэргэшүүлэх сургалтад Говь-Алтай аймгийн Автотээврийн төвийн тээвэр зохицуулагч А.Мөнхзулцацрах, Хөвсгөл аймгийн Автотээврийн төвийн тээвэр зохицуулагч Э.Нямдорж, Орхон аймгийн Автотээврийн төвийн тээврийн мэргэжилтэн Б.Алтантуяа, тээвэр зохицуулагч Д.Эрдэнэчимэг нар хамрагдсан. | 100 |

| | | | | | |
|-----------|--|--------------|----------|---|--|
| <p>50</p> | <p>Тус үйлдвэрийн газрын 2022 оны авлигын эсрэг хэлтэстэй хамтран 2022.02.23-нд үйлдвэрийн газрын шинээр томилгогдоон үндсэндээ албан хаагчид болон ашиг сонирхлын мэдүүлэг гаргалгаар албан хаагч нартыг авлигын эсрэг хууль тогтоож, авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх мэдүүлгийг дээшлүүлэх зорилгоор цахим сургалт зохион байгуулсан.</p> <p>✓ 2022.03.04-нд үйлдвэрийн газрын нийт үндсэндээ албан тушаалтнуудад "Авлигын гэмт хэрг" сэдэвт сургалтыг зохион байгуулсан.</p> | <p>ЗСХНХ</p> | <p>-</p> | <p>1.2.5. Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг тогтмол зохион байгуулах</p> <p>Шалгуур үзүүлэлт: Авлига, ашиг сонирхлын зөрчлийн I-IV үйлдвэр</p> <p>Хугацаа: 2022</p> <p>Зорилготой түвшин: I-IV үйлдвэр</p> <p>Төлөвлөгөөнд тусгагдсан 2 ажил биелсэн байна.</p> | |
| | <p>Зорчигч тээврийн хэлтсийн 2022 оны үндэслэлийн төлөвлөгөөнд "Тээвэр зохицуулагч нарын үр чадварыг нэмэгдүүлэх, ухаалаг тээврийн системийг хөгжүүлэх" тухай онол, практик хослуулан бүсчилсэн сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах гэж төлөвлөсний дагуу бүсчилсэн сургалтнуудыг зохион байгуулсан. Үндэ</p> <ul style="list-style-type: none"> • 2022.03.30-2022.04.05-ний өдрүүдэд Зүүн бүсийн 3 аймгийн тээвэр зохицуулагч нартыг сургалт хийсэн. Сургалтад 17 тээвэр зохицуулагч 6 гэрээт ажилтан хамрагдсан бөгөөд нийт 23 ажилтан хамрагдсан. • 2022.04.11-12-ний өдрүүдэд Улаанбаатар хот дахь Сонгинохайрхан, Баянзүрх зорчигч тээврийн төвийн 33 тээвэр зохицуулагч, лавлах үйлчилгээний 11 ажилтан хамрагдсан. • 2022.04.13-23-ний өдрүүдэд Баруун бүсийн 8 аймгийн тээвэр зохицуулагч нартыг сургалт хийсэн. Сургалтад 35 тээвэр зохицуулагч, 1 гэрээт ажилтан, 4 тасалбар түгээгч хамрагдсан бөгөөд нийт 40 ажилтан хамрагдсан. • 2022.04.26-2022.05.03-ний өдрүүдэд Хойд бүсийн 5 аймгийн тээвэр зохицуулагч нартыг сургалт хийсэн. Сургалтад 36 ажилтан хамрагдсан. <p>2022 оны эхний хагас жилийн байдлаар 16 аймаг, 2 салбарын 143 ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулсан.</p> | | | | |

| | | | | | | |
|-----|--|---|--|-----|---|-----|
| | | | | | Авлигын гэмт хэрэг, зөрчлийн илрүүлэлт, авлигын эсрэг үйл ажиллагаанд иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор техникийн хяналтын үзлэгт орж байгаа тээврийн хэрэгслүүдэд иргэд, аж ахуйн нэгжээс өргөдөл гомдол хүлээн авах 110 дугаарын утасны сурталчилгаа бүхий авто стикерийг байршуулан ажиллаж байна | |
| | | 1.2.6 Автотээврийн нэгдсэн лавлах 1900-1234 тусгай дугаараар иргэдэд хүргэх үйлчилгээг өргөжүүлж, үйлчилгээг 24 цагаар ажиллуулж эхлэх Шалгуур үзүүлэлт: 24 цагийн хуваарьт шилжсэн байх Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Автотээврийн нэгдсэн лавлах 1900-1234 тусгай дугаарын үйлчилгээг 24 цагаар ажиллуулж эхэлсэн байна. | | ХУХ | "Автотээврийн нэгдсэн лавлах 1900-1234" тусгай дугаарын үйлчилгээ нь 2022.06.06-ний өдрийн байдлаар нийт 248,697 дуудлага хүлээн авсан бөгөөд 2022.04.11-ний өдрөөс 24 цагаар ажиллаж эхэлсэн. Энэ хугацаанд 22:00-07:00 цагийн хооронд нийт 7,447 дуудлага хүлээн авч 1,235 гомдлыг утсаар шийдвэрлэж 36 гомдлыг санал, хүсэлт, гомдлын хуудсаар бүртгэж холбогдох хэлтэст шилжүүлсэн. | 100 |
| 1.3 | Улс хот хоорондын ачаа, зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/24 дүгээр тушаалаар батлагдсан "Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм" -ийн дагуу зохион байгуулах | 1.3.1. Улс, хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгчийг сонгон гэрээ байгуулан батлагдсан тээвэрлэлтийн чиглэл, үйлчилгээний давтамж, цагийн хуваарийн дагуу үйлчилгээг зохион байгуулах; Шалгуур үзүүлэлт: Үйлчилгээнд ашиглагдаж байгаа том оврын автобусны эзлэх хувь Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Улс, хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгчийг сонгон гэрээ байгуулан батлагдсан тээвэрлэлтийн чиглэл, үйлчилгээний давтамж, цагийн хуваарийн дагуу үйлчилгээг зохион байгуулсан байна. | | ЗТХ | 2022 оны эхний хагас жилийн байдлаар хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээг 56 чиглэлд 63 аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулан 708 тээврийн хэрэгсэл болон 1475 жолоочтойгоор тээвэрлэлтийг гүйцэтгэж байгаа бөгөөд 16 чиглэлийн үйлчилгээ зорчигч урсгалтай холбоотойгоор түр зогссон. Батлагдсан 72 чиглэлд үйлчилгээг зохион байгуулсан. Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллагуудын гэрээг улирал тутам дүгнэн ажиллаж байгаа бөгөөд дутагдалтай болон гэрээ дүгнүүлээгүй аж ахуйн нэгж байгууллагуудад тухай бүр мэдэгдэл хүргүүлэн ажиллаж байна. Мэдээллийн санд хамрагдсан тээврийн хэрэгслүүдийг төрлөөр нь ангилахад 45 хүний суудалтай том оврын автобус 598, 24-36 хүний суудалтай дунд оврын автобус 20, суудлын автомашин 90 байна. Нийт 708 тээврийн хэрэгслээс том оврын автобус 84,4%-ийг эзэлж байгаа бөгөөд 2022.12.31-ний дотор 253 тээврийн хэрэгсэл буюу 35,7%-нь насжилтаар хасагдана. | 70 |

| | | | | | | |
|--|--|---|---|------------|---|-----------|
| | | <p>1.3.2. Хот хоорондын нийтийн тээврийн замналын паспорт хөтлөх Шалгуур үзүүлэлт: Замналын паспорт баяжуулалт хийгдэж, хөтөлсөн тоо Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Үлдсэн 9 чиглэлийн 4 чиглэлийн замналын паспортыг хөтөлсөн байна.</p> | <p>10 сая.төг</p> | <p>ЗТХ</p> | <p>Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар хот хоорондын нийтийн тээврийн 109 чиглэл батлагдсан бөгөөд 100 чиглэлийн замналын паспортыг бүрэн хөтөлж мэдээллийн санг үүсгэсэн. Үлдсэн 9 чиглэлийн замналын паспортыг 2022 онд багтаан хийхээр төлөвлөн холбогдох ажлуудыг хийж байна.</p> | <p>50</p> |
| | | <p>1.3.3 Автозамаар олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрлийн бичгүүдийг бэлтгэн хэвлүүлж, холбогдох улсуудад хүргүүлж, тээвэрлэлтийн хэвийн нөхцөлийг бүрдүүлэх Шалгуур үзүүлэлт: Зөвшөөрлийн бичгүүд бэлтгэгдэж, тээвэрлэлт явагдах нөхцөл бүрдүүлэх Хугацаа: II-IV улирал Зорилтот түвшин: Автозамаар олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрлийн бичгүүдийг бэлтгэн хэвлүүлэх тендерт шаардагдах техникийн шаардлагыг боловсруулах</p> | <p>10 сая.төг /Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбоо/</p> | <p>АТХ</p> | <p>Хугацаа болоогүй.</p> | <p>-</p> |
| | | <p>1.3.4 Монгол, Хятадын хилийн Замын-Үүд-Эрзэн автозамын боомтын дундын бүсэд чингэлэг солилцох үйл ажиллагааг зохион байгуулах Шалгуур үзүүлэлт: Улс хоорондын ачаа тээвэрлэлт саадгүй явагдах нөхцөл бүрдсэн байх</p> | <p>Засгийн газрын нөөц хөрөнгө, 700 сая.төг</p> | <p>АТХ</p> | <p>Монгол Улсын Ерөнхий сайдын 2021.12.27-ны өдрийн 196 дугаар захирамжын хүрээнд тусгаарлалтын дэглэмд үүрэг гүйцэтгэж буй 3 аж ахуйн нэгж байгууллагын 56 тээврийн хэрэгслээр түрээсийн гэрээ, 50 жолоочтой хариуцлагын гэрээ байгуулж, тээвэрлэлтийг 2022.01.11-ний өдрөөс 2022.05.15-ны өдөр хүртэл хийсэн. 2022.05.16-ны өдрөөс эхлэн иргэдийн 30, хил хамгаалахын 30, нийт 60 тээврийн хэрэгсэл хоосон чингэлэг ачиж 0 цэгт хүргэж өгч ажиллаж байна. Мөн орж ирж байгаа чингэлэг 40 тээврийн хэрэгслээр гарч байсан нь багасч 30 тээврийн хэрэгслээр ачаатай</p> | <p>70</p> |

| | | | | | |
|--|---|--|-----|--|----|
| | <p>Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Тээвэрлэлтийг зохион байгуулсан байна.</p> | | | <p>чингэлэг орж ирж байна. 2022.06.05-ны өдөр нийт 60 тээврийн хэрэгслээр 727,368 тонн ачаа тээвэрлэгдэж, 2022.01.11-ний өдрөөс 2022.06.05-ны өдөр хүртэл хугацаанд Улсын хилээр нийт өссөн дүнгээр 7103 тээврийн хэрэгслээр 173900.2 тн ачаа орж ирснээс чингэлэг 20*3723, 40*5171, импорт 1978, тээврийн хэрэгсэл 5 ширхэг овор ихтэй ачаа хилээр нэвтэрсэн болно. Бүс нутгийн ложистикийн төвөөс Эрэн хотын чиглэлд 20*1243, 40*2527, нийт 3770 чингэлэг буцсан. Бүс нутгийн ложистикийн төвөөс Улаанбаатар хотруу 7650 тээврийн хэрэгсэл, бусад аймаг орон нутагт 770 тээврийн хэрэгсэл, нийт 8414 тээврийн хэрэгсэл Замын-Үүд сумаас гарах хөдөлгөөнд оролцсон байна. Тус үйлдвэрийн газрын Автотээврийн хяналтын улсын байцаагч бүс нутгийн ложистикийн төв, Замын-Үүд боомт, Замын-Үүд чөлөөт бүсээр дамжин өнгөрч байгаа ачаа тээврийн хэрэгслийн жинд Зам, тээврийн хөгжлийн төвтэй хамтран байнгын хяналт шалгалтыг явуулж ажиллаж байна. Улс хоорондын ачаа тээвэрлэлт саадгүй явагдах нөхцөл бүрдсэн.</p> | |
| | <p>1.3.5 Замын-Үүд – Эрэн боомтоос бусад БНХАУ-тай хиллэдэг Бичигт, Булган боомтоор импортын ачаа нэвтрүүлэх чиглэлээр тээвэр зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх Шалгуур үзүүлэлт: Бичигт, Булган боомтоор импортын тээвэрлэлт явагдсан байх Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Тээвэрлэлтийг эхлүүлсэн байна.</p> | | АТХ | <p>1. Ховд аймгийн Булган боомтоор 2022.01.01-04.06-ны өдрийн хооронд нийт 78 тээврийн хэрэгслээр 956 тн ачаа бараа орж ирсэн байна. 2. Сүхбаатар аймгийн Бичигт боомтын үйл ажиллагаа нөхцөл байдалтай 2022 оны 03 дугаар сарын 27-ны өдөр ЗТХЯамны АТБХЗГ-ын дарга Ё.Жаргалсайхан, Автотээврийн үндэсний төвийн Дэд захирал Б.Мөнхгарьд, Ачаа тээврийн хэлтсийн мэргэжилтэн Г.Мөнхтулга, 0146 дугаар ангийн захирагч хурандаа О.Азхүү, Гаалийн газрын дарга Н.Амарбаатар, хилийн Тагнуулын газрын ажилтан Г.Мягмарсүрэн нартай боомтын нөхцөл байдлын талаар хуралдав. Улс хоорондын тээвэрлэлтийг хэрхэн эхлүүлэх талаар Монгол Улсаас БНХАУ-д суугаа элчин сайдын яамаар дамжуулан албан шугамаар хэлэлцэх болон одоо байгаа нөхцөл байдалтай уялдуулан тээвэрлэлтийг зохион байгуулах саналыг уламжлах тухай мэдэгдсэн. Ховд аймгийн Булган боомтоор бараа, материалыг 2022.01.17-ны өдрөөс эхэлж тээвэрлэсэн ба өссөн дүнгээр нийт 410 т/х 6928.5 тн ачаа тээвэрлэсэн байна. Сүхбаатар аймгийн Бичигт боомт өнөөдрийн байдлаар хөдөлгөөнгүй байна.</p> | 70 |
| | <p>1.3.6 Монгол Улсын хилээр нэвтрэн тээвэрлэлт хийж буй гадаадын тээврийн хэрэгсэлд</p> | | ХҮХ | <p>Алтанбулаг хилийн боомтоор 2022 оны эхний хагас жилд ОХУ-руу гарсан ачааны тээврийн хэрэгсэл 6299, ОХУ-аас Монгол улс руу орж ирсэн 6072 том оврын ачааны тээврийн</p> | 70 |

| | | | | | | |
|--|--|--|--|-----|--|-----|
| | | <p>тавих хяналт, шалгалтыг сайжруулж, хариуцлага тооцож ажиллах</p> <p>Шалгуур үзүүлэлт: Гадаадын тээвэрлэгчид зөвшөөрлийн бичиггүйгээр хил нэвтэрч тээвэрлэлт хийх явдал арилсан байх</p> <p>Хугацаа: I-IV улирал</p> <p>Зорилтот түвшин: Зөвшөөрлийн бичгийн 2-р улирлын мэдээ тайланг ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.</p> | | | <p>хэрэгсэл шалгаснаас зөвшөөрлийн бичиггүй нийт 668 тээврийн хэрэгсэл орж ирсэн.</p> <p>ЗТХ-ийн сайдаас ковид цар тахалтай холбоотойгоор гадаадын тээврийн хэрэгсэлд тавих хяналт, шалгалтыг түр зогсоох тухай чиглэлийг АТБХЗГ-аар дамжуулан өгсөн тул зөвшөөрлийн бичиггүй тээврийн хэрэгсэлд арга хэмжээ тооцолгүй нэвтрүүлж байна. Зөвшөөрлийн бичгийг "Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбоо"-ноос олгож байгаа болно.</p> | |
| | | <p>1.3.7 Олон улсын, улсын чанартай авто замаар ачаа тээвэрлэлт хийж буй тээврийн хэрэгсэл стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд тавих хяналтыг сайжруулах, ЗТХЯ, мэргэжлийн хяналт, Тээврийн цагдаагийн албатай хамтран компани т ажил зохион байгуулах</p> <p>Шалгуур үзүүлэлт: Хяналт, шалгалтын ажил зохион байгуулагдаж, тодорхой үр дүн гарсан байх</p> <p>Хугацаа: I-IV улирал</p> <p>Зорилтот түвшин: Төлөвлөгөөт ажил 50-аас доошгүй хувь хэрэгжсэн байна.</p> | | ХУХ | <p>ЗТХ-ийн сайдын 2022.03.11-ний өдрийн онлайн хурлаар замын эвдрэл гэмтэл, даац хэтрүүлэлтэй холбоотой олон улсын болон улсын, орон нутгийн чанартай авто замд хяналт шалгалтыг зохион байгуулах үүрэг чиглэл өгсөн. Тус ажлын хүрээнд "АТҮТ" ТӨҮГ болон орон нутгийн ААТ-үүд хамтарсан удирдамжийн дагуу 2022.03.20-ны өдрөөс эхлэн тус зохион байгуулж байна. Улсын хэмжээнд нийт 940 гаруй тээврийн хэрэгсэл шалгалтад хамрагдаж Автотээврийн хэрэгсэлд тавих техникийн ерөнхий шаардлага MNS 4598:2020 стандартын шаардлагыг хангаагүй даац хэтрүүлсэн 28 тээврийн хэрэгсэлд нийт 4.200.000 төгрөгийн торгууль оногдуулж, 18 тээврийн хэрэгслийн зөрчлийг газар дээр нь арилгуулж, иргэд, жолооч, ААНБ-д стандарт дүрэм журам танилцуулж ажилласан.</p> <p>2022.04.01-2022.05.01-ний өдрийн хооронд ЗТХЯ-аас зохион байгуулж буй олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжийн ашиглалтын хугацааг уртасгах, арчлалт хамгаалалтад анхаарах, замын эвдрэл гэмтлийг багасгах, "Автотээврийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS4598:2020 стандартын шаардлага хэрэгжилтийг хангуулж ажиллах талаар ЗТХЯ, ЗТХТ, ТЦА-тай хамтарсан "Саадгүй тээвэр-Сайн замаар" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулан ажилласан. Хяналт шалгалтаар удаа дараа зөрчил гаргасан ААНБ-уудад АТХУБ-ийн хугацаатай албан шаардлага хүргүүлсэн. Тус арга хэмжээний хүрээнд нийт 3105 тээврийн хэрэгслийг шалгаж, 1098 тээврийн хэрэгслийн зөрчлийг газар дээр нь арилгуулж ажилласан. Даац хэтрүүлсэн 76 зөрчилд 11.135.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан. Цаашид жин</p> | 100 |

| | | | | | | |
|-----|---|--|--------------|-----|--|----|
| | | | | | тонн хэтрүүлэн ачихгүй байх талаар тээвэрлэлт гүйцэтгэж байгаа иргэн, ААНБ-ууд болон жолооч нарт зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. | |
| 1.4 | Улс хоорондын тээвэрлэлтийн эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр олон улсын гэрээ хэлэлцээр байгуулах, хамтын ажиллагааг өргөжүүлэх | <p>1.4.1 Монгол, Хятадын хилийн авто замын боомтуудаар хийгдэх уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг тасралтгүй хэвийн явуулах чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч ажиллах</p> <p>Шалгуур үзүүлэлт: Тээвэрлэлт хэвийн явагдсан байх</p> <p>Хугацаа: I-IV улирал</p> <p>Зорилтот түвшин: Тээвэрлэлтийн тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангасан байна.</p> | 38 сая.төг | АТХ | <p>Сүхбаатар аймгийн Бичигт боомтын улс хоорондын тээвэрлэлтийг эхлүүлэх Монголын талын боомтын бэлэн байдалтай танилцах зорилгоор ЗТХЯ-ны АТБХЗГ-ын дарга Ё.Жаргалсайхан, Автотээврийн үндэсний төвийн Дэд захирал Б.Мөнхгарьд, Ачаа тээврийн хэлтсийн мэргэжилтэн Г.Мөнхтулга нар 2022.03.27-ны өдөр Бичигт боомт дээр ажиллаж, 0146 дугаар ангийн захирагч хурандаа О.Азхүү, Гаалийн газрын дарга Н.Амарбаатар, хилийн Тагнуулын газрын ажилтан Г.Мягмарсүрэн нартай уулзалт зохион байгуулж, боомтын нөхцөл байдлын талаар хуралдсан. Улс хоорондын тээвэрлэлтийг хэрхэн эхлүүлэх талаар Монгол Улсаас БНХАУ-д суугаа элчин сайдын яамаар дамжуулан албан шугамаар хэлэлцэх болон одоо байгаа нөхцөл байдалтай уялдуулан тээвэрлэлтийг зохион байгуулах саналыг уламжлахаар болсон. Одоогийн байдлаар хятадын талаас Бичигт, Баянхошуу боомтын үйл ажиллагааг эхлүүлэх мэдээлэл өгөөгүй, боомт хөдөлгөөнгүй байна.</p> <p>Өмнөговь аймгийн Гурван тэс сумын Шивээхүрэн хилийн боомтын үйл ажиллагаа 2022.05.25-ны өдөр эхэлсэн ба халдвар, хамгааллын дэглэмийг сахиулан хилийн 0 цэг дээр чингэлэг солин тээвэрлэлтийг гүйцэтгэж байна. Тээвэрлэлт эхэлснээс хойш өссөн дүнгээр нийт 754 тээврийн хэрэгсэл, 3016 чингэлэгээр нүүрс тээвэрлэсэн байна.Одоогийн байдлаар тээвэрлэлт хэвийн үргэлжилж байна.</p> | 70 |
| | | <p>1.4.2. Монгол Улс болон БНХАУ-ын ӨМӨЗО, ШУӨЗО-ны Автотээврийн төлөөлөгчдийн 2022, 2023 онд ашиглах зөвшөөрлийн бичиг солилцох уулзалтуудыг тус тус зохион байгуулах</p> <p>Шалгуур үзүүлэлт: Улс хоорондын тээвэрлэлтэд үүсч буй асуудлууд шийдэгдсэн байх</p> <p>Хугацаа:</p> | 17.3 сая.төг | АТХ | <p>Тус үйлдвэрийн газраас БНХАУ-ын Хөх хот дахь Ерөнхий консулын газраар дамжуулан 2022 онд зөвшөөрлийн бичиг солилцох тухай 3/1647 тоотыг 2021.12.28-ны өдөр ӨМӨЗО-ны ЗХТТ-д хүргүүлсэн. ӨМӨЗО-ны ЗХТТ-аас 2021.12.29-ний өдрийн (2021)1340 тоотгоор 2022 оны зөвшөөрлийн /А-80, А-С-30, С-38000, D-50000, E-1000, F-4000 ширхэг/ бичгийг Монгол Улсаас ӨМӨЗО-ны Хөх хотод суугаа консулаар дамжуулан солихыг зөвшөөрсөн тухай бичгийг ирүүлсэн. Зөвшөөрлийн бичгийг Өмнөговь аймгийн Гашуунсүхайд хилийн боомтоор хүлээн авсан.</p> <p>БНХАУ-ын ШУӨЗО-ны ЗХТТ-аас 2021.10.08-ны өдрийн 2021M004 тоотгоор 2022 онд ашиглагдах зөвшөөрлийн /С-</p> | 70 |

| | | | | | | |
|--|--|--|-----------------------|------------|---|--|
| | | <p>III-IV улирал Зорилтот түвшин: Бэлтгэл ажлыг хангасан байна.</p> | | | <p>6000, F-100/ бичгийг солилцох бусад зөвшөөрлийн бичгийг үргэлжлүүлэн ашиглах тухай саналыг ирүүлсэн. Тус үйлдвэрийн газраас ШУӨЗО-ны ЗХТТ-аас ирүүлсэн саналыг зөвшөөрсөн тухай 3/1295 тоотыг 2021.10.14-ний өдөр хүргүүлсэн. ШУӨЗО-ны ЗХТТ-аас 2021.11.16-ны өдрийн 2021M005 тоотор ковид-19 өвчний нөхцөл байдлаас шалтгаалан өөрсдийн хэвлэсэн зөвшөөрлийн бичиг /С-6000, F-100/-ийг ашиглах талаар албан тоот ирүүлсэн. Тус үйлдвэрийн гзраас 2021.12.08-ны өдрийн 3/1538 тоотор ковид-19 өвчний нөхцөл байдлаас шалтгаалан өөрсдийн хэвлэсэн зөвшөөрлийн бичгийг ашиглахыг дэмжсэн тухай тоотыг ШУӨЗО-ны ЗХТТ-д хүргүүлсэн. 2023 онд ашиглах зөвшөөрлийн бичиг хэвлүүлэх болон солилцох уулзалтын хугацаа болоогүй байна.</p> | |
| | | <p>1.4.3 Европын холбооны улсууд, ОХУ-тай байгуулсан засгийн газар хоорондын автотээврийн хэлэлцээрийн хэрэгжилтийг хангуулах ээлжилт уулзалтад оролцох Шалгуур үзүүлэлт: Уулзалт зохион байгуулагдсан байх Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: ЗТХЯ-наас ээлжит хурлын тов ирүүлсэн байна.</p> | <p>30 сая.төг</p> | <p>АТХ</p> | <p>Зам, тээврийн хөгжлийн яамнаас Европын холбооны улсууд, ОХУ-тай байгуулсан засгийн газар хоорондын автотээврийн хэлэлцээрийн хэрэгжилтийг хангуулах ээлжилт уулзалтын товын талаар мэдээлэл ирүүлээгүй байна. Европын холбооны улсууд, ОХУ-тай байгуулсан засгийн газар хоорондын автотээврийн хэлэлцээрийн хэрэгжилтийг хангуулах ээлжит уулзалтыг ЗТХЯ-наас зохион байгуулдаг. Хугацаа болоогүй.</p> | |
| | | <p>1.4.4 "Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн хүрээнд хамтарсан хорооны хурлыг ЗТХЯ-тай хамтран зохион байгуулах Шалгуур үзүүлэлт: Хурал зохион байгуулагдсан байх Хугацаа:</p> | <p>20 сая.төг</p> | <p>АТХ</p> | <p>"Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн хүрээнд хамтарсан хорооны хурлын тов шийдэгдээгүй байна. Хугацаа болоогүй.</p> | |

| | | | | | | |
|-----|--|--|---|-----|--|-----|
| | | III-IV улирал | | | | |
| | | 1.4.5 "Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн хүрээнд Монгол Улс, БНХАУ, ОХУ-д ашиглах зөвшөөрлийн бичиг хүлээн авах; Шалгуур үзүүлэлт: Зөвшөөрлийн бичиг хүлээн авсан байх Хугацаа: IV улирал | - | АТХ | "Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн хүрээнд Монгол Улс, БНХАУ, ОХУ-д ашиглах зөвшөөрлийн бичгийг үргэлжлүүлэн ашиглахаар тохиролцсон. | 100 |
| 1.5 | Жуулчин тээвэрлэлтийн үйлчилгээг зохион байгуулах, бүртгэл хяналтын тогтолцоог бүрдүүлэх; | 1.5.1. Жуулчин тээврийн үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /www.e-mongolia.mn/-аар дамжуулан зохион байгуулах Шалгуур үзүүлэлт: www.e-mongolia.mn –д бүртгэлтэй жуулчин тээвэрлэгчийн тоо Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Олон нийтийн сүлжээгээр дамжуулан иргэдэд жуулчин тээврийн үйлчилгээний талаарх мэдээллийг хүргэсэн байна. | - | ЗТХ | Жуулчин тээврийн ААНБ-уудад жуулчин тээврийн үйлчилгээг e-mongolia системд нэвтэрсэн талаарх танилцуулгыг бэлтгэж байна. Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /www.e-mongolia.mn/-аар дамжуулан 3 аж ахуйн нэгж байгууллага хүсэлт гаргасан бөгөөд шаардлага хангасан 1 аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулсан. ААНБ-ууд Жуулчин тээврийн үйлчилгээг И-Монголиа сайтаар дамжуулан хүсэлт гаргах боломжтой талаар мэдээллийг үйлдвэрийн газрын фэйсбүүк пэйж хуудсаар иргэд, олон нийтэд сурталчилсан. | 70 |
| 1.6 | Иргэдэд тээврийн үйлчилгээг ойртуулах зорилгоор тээшний хэмжээг тогтоох жин хэмжүүр, тээш хадгалах зориулалтын | 1.6.1 Илгээмжийн ачааг хүлээн авах, бүртгэлжүүлэх, хадгалах, тээвэрлэх, хүлээлгэн өгөх үйлчилгээг автобуудалтай аймгуудад зохион байгуулах; Шалгуур үзүүлэлт: Зорчигчийн тээш хүлээн авах цэгүүдийн тоо Хугацаа: | - | АТХ | 1.Баянхонгор аймгийн Автотээврийн төв 2022.01.07-ны өдрөөс эхлэн автобуудлаар дамжуулан илгээмжийн ачаа тээшийг хүлээн авах, бүртгэлжүүлэх, түр хадгалах үйлчилгээг эхлүүлсэн бөгөөд 2022.06.05-ны өдрийн байдлаар 8,269,198 төг төвлөрүүлэн ажиллаж байна. 2. Завхан аймгийн Автотээврийн төв 2022.01.23-ны өдрөөс эхлэн автобуудлаар дамжуулан илгээмжийн ачаа тээшийг хүлээн авах, бүртгэлжүүлэх, түр хадгалах үйлчилгээг | 100 |

| | | | | | | |
|-----|--|---|---|--------------|---|----|
| | байрыг бий болгох, тээшний тасалбар олгох | I-IV улирал Зорилтот түвшин: Өвөрхангай, Өмнөговь, Архангай аймгийн автобуудалд илгээмжийн ачааг бүртгэлжүүлэх ажлыг эхлүүлсэн байна. | | | эхлүүлсэн бөгөөд 2022.06.05-ны өдрийн байдлаар 2,997,300 төг төвлөрүүлэн ажиллаж байна. 3.Дархан-Уул аймгийн Автотээврийн төв 2022.03.12-ны өдрөөс эхлэн автобуудлаар дамжуулан илгээмжийн ачаа тээшийг хүлээн авах, бүртгэлжүүлэх, түр хадгалах үйлчилгээг эхлүүлсэн бөгөөд 2022.06.05-ны өдрийн байдлаар 3,658,662 төг төвлөрүүлэн ажиллаж байна. 4.Өвөрхангай аймгийн Автотээврийн төв 2022.02.14-ны өдрөөс эхлэн автобуудлаар дамжуулан илгээмжийн ачаа тээшийг хүлээн авах, бүртгэлжүүлэх, түр хадгалах үйлчилгээг эхлүүлсэн бөгөөд 2022.06.05-ны өдрийн байдлаар 1,617,600 төг төвлөрүүлэн ажиллаж байна. 5.Архангай аймгийн Автотээврийн төв 2022.01.01-ны өдрөөс эхлэн автобуудлаар дамжуулан илгээмжийн ачаа тээшийг хүлээн авах, бүртгэлжүүлэх, түр хадгалах үйлчилгээг эхлүүлсэн бөгөөд 2022.06.05-ны өдрийн байдлаар 1,169,388 төг төвлөрүүлэн ажиллаж байна. 6.Увс аймгийн Автотээврийн төв 2022.02.18-ны өдрөөс эхлэн автобуудлаар дамжуулан илгээмжийн ачаа тээшийг хүлээн авах, бүртгэлжүүлэх, түр хадгалах үйлчилгээг эхлүүлсэн бөгөөд 2022.06.05-ны өдрийн байдлаар 931,788 төг төвлөрүүлэн ажиллаж байна. 7.Өмнөговь аймгийн Автотээврийн төв 2022.01.20-ны өдрөөс эхэлсэн бөгөөд орлогыг тухай бүр төвлөрүүлэн ажиллаж байна. | |
| 1.7 | Мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох үйл ажиллагааг зохих журамд заасны дагуу зохион байгуулах; | 1.7.1. Автотээврийн тухай хууль, ЗТБХБЯам, БСШУЯ-ны хамтарсан 2010 оны 161/229 тоот тушаалын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах Шалгуур үзүүлэлт: Мэргэшсэн жолоочийн шалгалт авч, үнэмлэх олгосон тоо Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Мэргэшсэн жолоочийн 12500 удаагийн шалгалтыг авч, 5200 үнэмлэх хэв олгосон байна. | - | ЗТХ-ийн МЖСТ | Авто тээврийн тухай хууль, Боловсролын тухай хууль болон Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 05 дугаар сарын 07-ний өдрийн 161/229 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох журам"-ын дагуу "Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох мэргэжлийн шалгалтын комиссыг Зам тээврийн хөгжлийн сайдын 2021.11.04-ны өдрийн А/176 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан. 2022.06.10-ний байдлаар 14,989 жолоочоос давхардсан тоогоор 27,671 удаа шалгалт авч 12,478 жолооч шалгалт тэнцсэнээс 6,903 үнэмлэх хэвлэж олгосон. | 90 |

| | | | | | | |
|-----|--|---|---|-----|--|-----|
| 1.8 | Ачаа, зорчигч тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тээврийн байгууллагад сахилга хариуцлагыг дээшлүүлэх, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангуулах ажлыг зохион байгуулах | <p>1.8.1. Улс, хот хоорондын зорчигч тээврийн жолооч нарт зориулсан мэдвэл зохих хууль, дүрэм, журам болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах талаар гарын авлага боловсруулах</p> <p>Шалгуур үзүүлэлт: Гарын авлага бэлэн болж, жолооч нарт хүргэгдсэн байх</p> <p>Хугацаа: II-IV улирал</p> <p>Зорилтот түвшин: Гарын авлагын загварыг гаргасан байна.</p> | - | ХҮХ | Хот хоорондын зорчигч тээврийн жолооч нарт зориулсан гарын авлагыг үндсэн 8 бүлэг 34 сэдвийн хүрээнд боловсруулж дууссан бөгөөд төслийг удирдлагуудад танилцуулах шатанд явж байна | 70 |
| | | <p>1.8.2 Онцгой нөхцөл байдал буюу зам тээврийн осол, цаг агаар замын нөхцөл байдлын хүндрэл болон техникийн эвдрэл, гэмтлээс шалтгаалсан саатал, бүх нийтийг хамарсан халдварт өвчний улмаас хөдөлгөөн хязгаарлагдсан тохиолдлуудад зорчигчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр шуурхай ажиллагаа зохион байгуулах, нэгдсэн судалгаа гаргах</p> <p>Шалгуур үзүүлэлт: Шуурхай арга хэмжээ авагдсан байх</p> <p>Хугацаа: I-IV улирал</p> <p>Зорилтот түвшин: Тээвэрлэлтийн явцад гарсан осол, саатлын үед шуурхай арга хэмжээ зохион байгуулж, зорчигчдын ая тухтай зорчих нөхцөлийг хангаж мэдээллийг холбогдох газруудад мэдэгдсэн байна.</p> | - | ХҮХ | <p>Тайлант хугацаанд тээвэрлэлтийн үеийн саатал 157 бүртгэгдсэн бөгөөд цаг агаар, замын нөхцөл байдлаас шалтгаалсан 19, техникийн саатал 97, бусад төрлийн саатал 41 тус тус бүртгэгдсэн байна.</p> <p>2022.03.22-24-ний өдрүүдэд Баян-Өлгий аймагт хүчтэй цасан болон шороон шуурга шуурч, цаг агаарын хүндрэлээс шалтгаалан зорчигчдын амь нас, эрүүл мэндэд эрсдэл учирч болзошгүй нөхцөл үүссэн тул тээвэрлэлтийг шуурхай удирдлагаар хангах ажлыг зохион байгуулж 1 тээврийн хэрэгслийн 25 зорчигчийг Баян-Өлгий аймгийн Бураатын даваан зүүн талд Баян энгэр цайны газар байршуулж, 77 зорчигчтой 4 тээврийн хэрэгслийн тээвэрлэлтийг хойшлуулах арга хэмжээг авч ажилласан.</p> <p>2022.04.10-ны өдөр нийт нутгаар орсон цасны улмаас бүх чиглэлийн замууд халтиргаа гулгаа үүссэн. Архангай аймгийн Түвшрүүлэх сумын нутагт байдаг Шар булгийн даваанд халтиргаа хулгаа үүсч тээврийн хэрэгслүүд шороон замаар явж уруудах үедээ УБ-Ар.Эрдэнэбулган чиглэлд гарсан 86 зорчигчтой 2 автобус шаварт суусан. Аймгийн онцгой байдлын албаны Зил-131 маркийн тээврийн хэрэгсэл болон АЗЗА ажиллаж замыг хэвийн болгосон. Мөн Өвөрхангай аймгийн Хархорин сум гарах хөдөлгөөнөө түр хаасантай холбоотойгоор 2 чиглэлийн 65 зорчигчтой 2 автобусыг Архангай аймгийн төв дээр зочид буудалд байрлуулсан. 2 чиглэлийн 52 зорчигчтой 2 тээврийн хэрэгслийг Архангай аймгийн төв дээр түр</p> | 100 |

| | | | | |
|--|--|--|--|---|
| | | | | <p>зогсоож Шар булгийн даваа хэвийн болж Хархорин сум тээврийн хэрэгсэл хэвийн нэвтрүүлж эхэлмэгц 04:00 цагт чиглэлийн дагуу хөдөлгөөнөө үргэлжлүүлсэн.</p> <p>Хойд болон баруун зүгийн нутгаар 2022.04.13-ны өдөр их хэмжээний цас орсны улмаас Дарханы Цайдамаас Хустайн даваа, Сэлэнгэ аймгийн Баянгол сумын хойд хэсгээр замын нөхцөл байдал хүндэрч, том оврын ачааны машинууд зам, гүүр хөндөлсөж түгжрэл үүссэн. Мөн хүчтэй цасан шуурга шуурч тээвэрлэлт гүйцэтгэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн тул зорчигчдын ая тухтай зорчих, аюул осолгүй тээвэрлэлт гүйцэтгэх зорилгоор болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлж 2022.04.13-ны өдрийн Да.Дархан-УБ-Да.Дархан, УБ-Да.Шарын гол, Ор.Баян Өндөр-УБ-Ор.Баян Өндөр, Хө.Мөрөн-УБ-Хө.Мөрөн, УБ-Бу.Булган чиглэлүүдэд 12:00 цагаас хойш тээвэрлэлт гүйцэтгэхээр төлөвлөгдсөн нийт 8 чиглэлийн 215 зорчигчтой 29 тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг цаг агаар, замын нөхцөл байдал сайжиртал түр хязгаарласан.</p> <p>Өвөрхангай, Баянхонгор аймгийн нутгаар 2022.04.13-15-ны өдрүүдэд их хэмжээний нойтон цас орж, цасан шуурга шуурсаны улмаас Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумаас Нарийнтээл сумын хоорондох улсын чанартай А0302 авто зам хаагдсан тул авто зам, замын байгууламжийг түр хаах ЗТХ-ийн сайдын тушаал гарч 2022.04.16-ны өдрийн 14:00 цаг хүртэл хаасан. Зам хаагдаж, тээвэрлэлт гүйцэтгэх боломжгүй болсонтой холбоотойгоор 2022.04.13-04.15-ны өдрүүдэд нийт 19 чиглэлийн 640 зорчигчтой 45 тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг цаг агаар, замын нөхцөл байдал сайжиртал түр хязгаарласан. Орон нутгаас тээвэрлэлтэд гарсан 125 зорчигчтой 3 чиглэлийн 5 тээврийн хэрэгслийг Баянхонгор аймагт, 44 зорчигчтой 3 тээврийн хэрэгслийг Говь-Алтай аймагт, Улаанбаатар хотоос тээвэрлэлтэд гарсан 194 зорчигчтой 5 чиглэлийн 8 тээврийн хэрэгслийг Өвөрхангай аймагт тус тус түр байршуулах, зорчигчдыг хоол унд, орон байраар хангах ажлыг зохион байгуулсан бөгөөд нийт 333 зорчигчтой 16 тээврийн хэрэгслийг /давхардсан тоогоор 27 тээврийн хэрэгслийн 653 зорчигч/ түр байршуулан холбогдох 25,887,000 төгрөгийн зардлыг даатгалын байгууллагаас гаргуулан ажилласан.</p> |
|--|--|--|--|---|

| | | | | | | |
|-----|---|---|------------|----------|---|-----|
| | | <p>1.8.3 Тээвэрлэгч ААНБ-ын өвөлжилтийн бэлтгэл ажлын явц техникийн бэлэн байдлыг хангуулах, сааталгүй үйлчлэх нөхцөл бүрдүүлсэн байдлыг газар дээр нь шалгах</p> <p>Шалгуур үзүүлэлт: Техникийн бэлэн байдал хангагдсан байх</p> <p>Хугацаа: I-IV улирал</p> <p>Зорилтот түвшин: Бэлтгэл ажил хангагдсан байна.</p> | - | ХУХ | <p>ЗТХЯ-ны ХШУДАГ-ын даргын баталсан зөвлөн туслах үйлчилгээний хөтөлбөрийн дагуу зорчигч тээврийн 3 ААНБ-д дотоод хяналт шалгалт болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, зөвлөмж хүргүүлсэн.</p> <p>2022 оны өвөлжилтийн бэлэн байдлыг шалгах ажлын хэсэг байгуулагдаж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.</p> | 70 |
| | | <p>1.8.4. Салбар, төв, ААНБ-уудад зорчигч, ачаа тээвэр, мэргэшсэн жолоочийн шалгалтын үйл ажиллагааны талаар холбогдох эрх зүйн акт, төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргасан шийдвэрийн талаар сурталчлах, сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх</p> <p>Шалгуур үзүүлэлт: Зохион байгуулсан сургалтын тоо</p> <p>Хугацаа: I-IV улирал</p> <p>Зорилтот түвшин: Төлөвлөгөөнд тусгагдсан 2 сургалт зохион байгуулсан байна.</p> | 30 сая.төг | ЗТХ, АТХ | <p>Салбар, төв, ААНБ-уудад мэргэшсэн жолоочийн шалгалтын үйл ажиллагааны талаар холбогдох эрх зүйн акт, төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргасан шийдвэрийн талаар сурталчлах, сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажлын хүрээнд 2022 оны эхний хагас жилд Дорноговь аймгийн Замын-Үүд сум, Замын-Үүд боомтонд 2022.02.23-25-ны өдрүүдэд, Дорноговь аймгийн Сайншанд сумын Автотээврийн төвд 2022.02.26-27-ны өдрүүдэд, Дорноговь аймаг, Хатанбулаг сум Ханги боомтод 2022.06.03-05-ны өдрүүдэд мэргэшсэн жолоочийн шалгалт авах ажлыг зохион байгуулсан.</p> <p>Мөн "Төрийн захиргааны автобааз" УТҮГ, "Айс марк" ХХК, "Блюбус"ХХК "Сутайн буянт" ХХК "АПУ" ХК зэрэг аж ахуйн нэгж байгуулагуудад мэргэшсэн жолоочийн шалгалт авах ажлыг зохион байгуулж холбогдох эрх зүйн акт, төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргасан шийдвэр журмын танилцуулан ажиллалаа.</p> <p>АТХ: Үйлдвэрийн газрын 2022 оны "Удирдах ажилтны зөвлөгөөн"-өөр аймгуудын Автотээврийн төв, салбарын дарга, нягтлан бодогч нарт улс хооронд болон дотоодын ачаа тээвэр зохион байгуулалт, тулгамдсан асуудлыг танилцуулах, 2022 онд ажиллах чиглэлийг өгсөн.</p> | 70 |
| 1.9 | Автотээврийн ажил үйлчилгээнд тавих төрийн хяналтыг тус яамтай байгуулсан "Автотээврийн | 1.9.1 ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын баталсан "Автотээврийн хяналтын чиглэлээр 2022 онд хамтран ажиллах төлөвлөгөө"-ний биелэлтийг ханган ажиллах | - | ХУХ | <p>ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын баталсан "Автотээврийн хяналтын чиглэлээр "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-тай хамтран ажиллах 2022 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд нийт 24 ажил тусгасан. Үүнээс 2022 оны эхний хагас жилийн байдлаар 16 ажил хийж</p> | 100 |

| | | | | | | |
|------|---|--|---|--------------------|--|----|
| | хяналтыг хамтран хэрэгжүүлэх" гэрээний дагуу хэрэгжүүлэх; | Шалгуур үзүүлэлт: Төлөвлөгөө батлагдаж, түүний хэрэгжилтийн хувиар Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Төлөвлөгөөнд тусгагдсан ажил 70-аас доошгүй хувь хангагдсан байна. | | | хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 11 ажил хийгдэж, 5 ажил хэрэгжилтийн шатанд явж байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар зорчигч тээврийн 7361, ачаа тээврийн 3587, тээвэрлэлтийн гэрээгүй зорчигч тээврийн 165 тээврийн хэрэгслүүдийг шалгаж, нийт 776 зөрчилд 85.750.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ оногдуулж 9054 иргэнд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажилласан байна. | |
| 1.10 | Техникийн хяналтын үзлэгийг тус яамтай байгуулсан "Автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх гэрээ"-ний дагуу гүйцэтгэх; | 1.10.1 Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх үйл ажиллагааг жилийн турш жигд зохион байгуулж, замын хөдөлгөөнд оролцож буй нийт тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулах Шалгуур үзүүлэлт: Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгслийн тоо Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: 394549 тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт хамруулсан байна | - | TXX | Техникийн хяналтын үзлэгийг суурин болон явуулын 51 төвөөр дамжуулан 2022.06.07-ны өдрийн байдлаар 294,406 /74.6%/ тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулсан. ЗТХЯ-ны улсын ахлах байцаагчийн 2022.01.17-ний өдрийн 38-07-001/006 тоот дүгнэлт, шалгалтын ажлын хэсгээс гаргасан санал, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/83 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн 2022.01.24-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022.01.28-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар үйлдвэрийн газрын Улаанбаатар хот дахь Баянгол, Сонгинохайрхан, Баянзүрх техникийн хяналтын үзлэг төв, Төв аймгийн Автотээврийн төвийн автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн. ЗТХЯ-ны улсын ахлах байцаагчийн дүгнэлтийн дагуу тус үйлдвэрийн газраас зөрчлийг арилгах талаар төлөвлөгөө гаргаж, тодорхой ажил зохион байгуулж, яаманд тайланг хүргүүлсэн. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022.02.11-ний өдрийн А/27 дугаар тушаалаар үйлдвэрийн газрын Улаанбаатар хот дахь Баянгол, Сонгинохайрхан, Баянзүрх техникийн хяналтын үзлэг төв, Төв аймгийн Автотээврийн төвийн автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээсэн | 70 |
| | | 1.10.2 Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ (RFID)-г бүрэн нэвтрүүлж, татвар даатгал, төлбөр тооцоо, бүртгэл хяналтын үйл ажиллагааг сайжруулах | | TXX ТХБХ MTX | Монгол улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолын 4 дэх заалтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ /RFID/-г урьдчилан бэлгэх, тээврийн хэрэгсэлд байрлуулах, бүртгэх үйл ажиллагааны 2022 оны нарийвчилсан төлөвлөгөө"-ний | 30 |

| | | | | | | |
|------|--|---|---|--------------|---|----|
| | | <p>Шалгуур үзүүлэлт: /RFID/ ялтасыг автомашинуудад суурилуулах ажил эхэлсэн байх</p> <p>Хугацаа: I-IV улирал</p> <p>Зорилтот түвшин: Албан журмын даатгагчдын холбооноос RFID ялтас хүлээн авсан байна.</p> | | | <p>санал авах бичиг 2022.02.18-ны өдрийн 04/728 тоотор ирүүлсэн бөгөөд санал хүргүүлэн хамтран ажиллаж байна. "Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ (RFID tag)-г урьдчилан бэлтгэх, тээврийн хэрэгсэлд байрлуулах, бүртгэх үйл ажиллагааны 2022 оны нарийвчилсан төлөвлөгөө" ЗТХЯ дээр боловсруулагдаж байна. Мөн техникийн хяналтын үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгсэлд RFID шошго суурилуулах ажлын хэсэг ЗТХЯ дээр байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд үйлдвэрийн газраас шаардлагатай мэдээллүүдийг гарган өгч хамтран ажиллаж байна.</p> <p>ISO180006C,63 стандартуудыг орчуулах, зөвлөмж гаргах ажлын даалгавар боловсруулж, ЗТХЯ-нд хүргүүлсэн. Албан журмын даатгагчдын холбооноос RFID ялтасыг хүлээн аваагүй байна.</p> | |
| 1.11 | <p>Жил бүрийн зорилтот түвшинд авто буудал, техникийн хяналтын үзлэгийн төвийн барилга барих хөрөнгийг тусган батлуулж хэрэгжүүлэх, орон нутагт авто замын дагуух үйлчилгээний цогцолбор, тээвэр логистикийн төв, терминал барьж байгуулах чиглэлээр Аймгийн Засаг дарга нар болон бусад байгууллагуудтай хамтран ажиллах;</p> | <p>1.11.1 Ховд болон Орхон аймагт автобуудлын барилгыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барьж байгуулах</p> <p>Шалгуур үзүүлэлт: Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь</p> <p>Хугацаа: I-IV улирал</p> <p>Зорилтот түвшин: Барилгын жишиг зураг төсвийг батлуулсан байна.</p> | Төр хувийн хэвшлийн түншлэл | ЗСХНХ | <p>Орхон аймгийн автотээврийн төвийн автобуудлын барилгын ажлыг тус аймгийн орон нутгийн санхүүжилтээр 2022-2023 онд барьж байгуулахаар төлөвлөж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг цахим хэлбэрээр 2022.01.18-ны өдөр зарлаж, 2022.02.18-ны өдөр нээсэн. Тендерт оролцогч "Шинжүү" ХХК шалгарсан. Гэрээний дагуу барилгын ажлыг 2022.05.18-ны өдөр эхлүүлсэн бөгөөд 621 м.кв талбайн суурийг ухаж үл бетон авах бэлтгэл ажил төлөвлөгөөний дагуу хийгдэж байна.</p> | 30 |
| | | <p>1.11.2 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд улсын чанартай авто замын дагуу 150-200 км тутамд үйлчилгээний цогцолбор байгуулах</p> <p>Шалгуур үзүүлэлт: Байгуулсан цогцолборын тоо</p> <p>Хугацаа: I-IV улирал</p> <p>Зорилтот түвшин:</p> | 60 сая.төг Төр хувийн хэвшлийн түншлэл | ЗТХ ЗСХНХ | <p>Одоо байгаа түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолборуудын байршлыг тогтоож, цогцолбор тус бүр дээр А, В, С ангилалын стандартын дагуу сайжруулах саналыг аймгийн АТТ-үүдээс авч нарийвчилсан судалгааг гарган ЗТХЯ-ны АТБХЗГ-т хүргүүлсэн.</p> <p>ЗТХЯ, БОАЖЯ, ХАҮТ-ын хамтарсан ажлын хэсэг 2022.04.15-ны өдөр хуралдаж, Архангай аймгийн Цэнхэр сум, Увс аймгийн Зүүнхангай сум, Хэнтий аймгийн Жаргалтхаан сум, Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумдад замын дагуух цогцолбор байгуулах 4 аж ахуйн нэгжийн ирүүлсэн санал, ТЭЗҮ, санхүүжилтийн асуудлыг хэлэлцэж, 2022.04.21-ний өдөр МҮХАТанхим "Заяын өгөөж" ХХК,</p> | 70 |

| | | | | | | |
|------|---|--|--|-------------|--|----|
| | | Хүсэлт, саналуудыг нэгтгэж, санал дүгнэлт гаргах, шалгаруулах Зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ. | | | "Драгон" холдинг, "Исун мод тур" ХХК, "Баян дойт" ХХК -тай хамтран ажиллах гэрээг байгуулсан. Дээрх компаниуд өөрсдийн хөрөнгөөр зам дагуух цогцолборыг байгуулахаар болсон. Төрөөс газрын асуудал болон байршлыг тогтоож, цахилгаан, дулаан, цэвэр, бохир усны шугам татах зэрэг үйл ажиллагаанд тухайн орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтран дэмжлэг үзүүлж ажиллаж байна. | |
| 1.12 | Тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох үйл ажиллагааг зохих журамд заасны дагуу иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэх, цахим хэлбэрээр зохион байгуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах; | 1.12.1 Автотээврийн хэрэгслийн гэрчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх Шалгуур үзүүлэлт: Гэрчилгээ цахим хэлбэрт шилжсэн байх Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Тээврийн хэрэгслийн гэрчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн байна. | | ТХБХ МТХ | Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээний үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсэгт холбогдох саналыг хүргүүлсэн. "Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ (RFID tag)-г урьдчилан бэлтгэх, тээврийн хэрэгсэлд байрлуулах, бүртгэх үйл ажиллагааны 2022 оны нарийвчилсан төлөвлөгөө" ЗТХЯ дээр боловсруулагдаж байна. | 70 |
| | | 1.12.2 Төрийн цахим мэдээлэл солилцох системд холбох төрийн үйлчилгээний жагсаалтад тусгагдсан автотээврийн салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах Шалгуур үзүүлэлт: Жагсаалтад багтсан тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулах Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Жагсаалтад багтсан 6 ажил үйлчилгээний хэрэгжилт хангагдсан байна. | | ТХБХ МТХ | МТХ-ийн дарга Нэргүй, ТЦА-ны ХМТХ-ийн дарга х/а Баттулга, И-Монгол академийн мэргэжилтэн Мөнхтулга нартай уулзаж ЗГХЭГ-ын даргын 2019 оны 84 дүгээр тушаалаар баталсан журмыг судлан үзсэний үндсэн дээр "e-mongolia" цахим үйлчилгээнд ашиглаж буй "Төрийн мэдээллийн сангаас гарах лавлагаа, тодорхойлолтын нэгдсэн маягт"-ыг нэвтрүүлэх саналыг хэлэлцэж, 2022.03.21-ний өдрийн 2/361 тоот албан бичгээр И-Монгол академид хүсэлт хүргүүлсэн. Тус үйлдвэрийн газраас 2022.05.12-нд "И-монгол" академийн үйлчилгээнүүддээ тээврийн хэрэгслийн шилжилтийн үйлчилгээг нэмж нийт 5 үйлчилгээ нэвтрүүлсэн. Жагсаалтад нийт 13 үйлчилгээг цахимжуулахаар төлөвлөсөн бөгөөд эхний хагас жилийн зорилтот түвшинд 6 ажил хэрэгжүүлэхээс 5 үйлчилгээ нэвтрүүлсэн ба 8 ажил 2022 оны сүүлийн хагас жилд хэрэгжүүлнэ. | 90 |

| | | | | | |
|--|---|---|-------------|--|----|
| | <p>1.12.3 Тээврийн хэрэгслийн бүртгэлийн программд нотариат, гааль, татвар, даатгал зэрэг байгууллагуудын сервирийг холбон иргэдэд цахимаар бүртгэлийн үйл ажиллагааг явуулах боломжийг бүрдүүлэх Шалгуур үзүүлэлт: Цахимаар хүргэсэн үйлчилгээний тоо Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Тээврийн хэрэгслийн бүртгэлийн программд холбогдох байгууллагуудын сервистэй холбогдож мэдээлэл авдаг болсон байна. VRS системд нэмэлт хөгжүүлэлт хийсэн байна.</p> | - | ТХБХ МТХ | <p>Тээврийн хэрэгслийн бүртгэлийн програмд нотариатын сервис холбож дууссан. Уг сервисийг холбосноор иргэн гэрээний материал цаасаар авчиргах шаардлагагүй болсон бөгөөд тухайн иргэнтэй хийсэн гэрээг цахимаар солилцдог болсон. Мөн бүртгэлийн мэргэжилтний ажлын үр бүтээмжийн дээшлүүлж аливаа хуурамч бичиг баримт, залилангаас хамгаалах үр ашигтай ажил болсон. Програмчлалын хувьд нотариатын сервистэй холбогдсоноор цахим маягт дээр тухайн А-тал, Б-талын мэдээллийг бүртгэлийн цахим архивт давхар хадгалж PDF форматаар автоматаар хадгалж архивладаг болсон. Тээврийн хэрэгслийн даатгалтай эсэх сервис хүлээгдэж байна.</p> | 70 |
| | <p>1.12.4 Тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйл ажиллагаанд тоон гарын үсгийг нэвтрүүлэх Шалгуур үзүүлэлт: Бүртгэлийн үйл ажиллагаанд тоон гарын үсэг нэвтэрсэн байх Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Цахим гарын үсгийн хүсэлтийг нийслэл дэх салбар нэгжүүдэд туршилтаар нэвтрүүлсэн байна.</p> | - | ТХБХ МТХ | <p>Тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн хийхэд шаардлагатай сервис солилцох тоон гарын үсгээр баталгаажсан албан хүсэлтийг хүлээн авч, гэрчилгээний төлбөрийг цахимаар гүйцэтгэх боломжийг бүрдүүлсэн. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн VRS систем дээр цахим хүсэлтийн хөгжүүлэлтийг бүрэн хийж дуусгасан. Дээрх цахим хүсэлт нэвтрүүлэхтэй холбоотой журмын төслийг ТХБХ боловсруулан ажиллаж байна. Тоон гарын үсгийн тест хийгдэж программ хөгжүүлэлт хийгдэж дууссан.</p> | 50 |
| | <p>1.12.5 Автотээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээлэл лавлагааг өмчлөгч, эзэмшигч болон эрх бүхий хууль хяналтын байгууллага цахимаар авах нөхцлийг бүрдүүлэх</p> | - | ТХБХ МТХ | <p>МТХ-ийн дарга Нэргүй, ТЦА-ны ХМТХ-ийн дарга х/а Баттулга, И-Монгол академийн мэргэжилтэн н.Мөнхтулга нартай уулзаж ЗГХЭГ-ын даргын 2019 оны 84 дүгээр тушаалаар баталсан журмыг судлан үзсэний үндсэн дээр "e-mongolia" цахим үйлчилгээнд ашиглаж буй "Төрийн мэдээллийн сангаас гарах лавлагаа, тодорхойлолтын нэгдсэн маяг"-ыг нэвтрүүлэх саналыг хэлэлцэж</p> | 90 |

| | | | | | | |
|------|--|---|---|-------|--|-----|
| | | <p>Шалгуур үзүүлэлт: Ажлын явц Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Тус ажлыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангасан байна.</p> | | | <p>2022.03.21-ний өдрийн 2/361 тоот албан бичгээр И-Монгол академид хүсэлт хүргүүлсэн. 2022 оны 4 сарын эхээр энэ асуудлаар И-Монгол академитай уулзалт хийж лавлагаа олгох асуудлыг хэрхэн шийдвэрлэх гаргалгааг хийж, эцэслэсэн. И монгол академаас 2022.04.18-ны 01/65 тоотоор ирсэн албан бичигт "III улиралд гүйцэтгэгч Ast vision компаниас систем хүлээж авсны дараа мэдээллийн сангаас гарах лавлагаа, тодорхойлолтын нэгдсэн маягт олгох үйлчилгээг нэвтрүүлнэ" гэж мэдэгдсэн.</p> | |
| 1.13 | Зам, тээврийн хөгжлийн яамны захиалгаар болон гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний хүрээнд чиглэл тус бүрээр төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус судалгаа хийж, яам болон бусад төрийн байгууллагуудыг мэдээллээр хангах | <p>1.13.1 Автотээврийн хэрэгсэлд суурилуулах утаа шүүгчийг дотоодод үйлдвэрлэх боломжийг судлах Шалгуур үзүүлэлт: Судалгааны хэрэгжилтийн хувиар Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Эхний шатны тайланг ЗТХЯ-нд хүргүүлж редакцийн санал авсан байна.</p> | - | СХЧУТ | <p>Судалгааны ажлын даалгаврын хүрээнд мэдээлэл цуглуулж эхний шатны тайланг боловсруулан 2022.02.23-ны өдрийн 1/239 тоот албан бичгээр ЗТХТ-д хүргүүлсэн. ЗТХТ-өөс судалгааны ажлын эхний шатны тайланг нэгтгэж, ЗТХЯ-нд хүргүүлсэн.</p> | 100 |
| | | <p>1.13.2 Гашуунсухайт боомтын чиглэлд ачаа тээвэрлэлт гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгсэлд байгаль орчинд ээлтэй технологи суурилуулах боломжийн талаар судалгаа хийх Шалгуур үзүүлэлт: Судалгааны хэрэгжилтийн хувиар Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Эхний шатны тайланг ЗТХЯ-нд хүргүүлж редакцийн санал авсан байна.</p> | - | СХЧУТ | <p>Гашуунсухайт боомтын чиглэлд ачаа тээвэрлэлт гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгсэлд байгаль орчинд ээлтэй технологи суурилуулах боломжийг судлах судалгааны ажлын дизайныг 5 бүлэг, 23 дэд бүлэгт хуваан боловсруулсан. Судалгаанд шаардлагатай мэдээллийг анхдагч болон хоёрдогч эх үүсвэрээс цуглуулж байна Судалгааг нийслэлийн нийтийн тээвэр, хийн түлш борлуулагч ААНБ, тээврийн хэрэгсэл, автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, холбогдох хууль, стандарт, журам, олон улсын туршлага зэргийг хамруулж гүйцэтгэсэн. Хүлээгдэж буй гүйцэтгэлээр төлөвлөгөөт хугацаандаа ЗТХЯ-нд 2022 оны 1/831 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> | 70 |
| | | <p>1.13.3 Хот хоорондын зорчигч тээвэр төлөвлөлтийн математик загварчлал боловсруулах.</p> | - | СХЧУТ | <p>Хот хоорондын зорчигч тээвэр төлөвлөлтийн математик загварчлал боловсруулах" судалгааны ажлын дизайныг 5</p> | 70 |

| | | | | | | |
|------|--|---|---|-------|---|-----|
| | | <p>Шалгуур үзүүлэлт: Судалгааны хэрэгжилтийн хувиар Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Эхний шатны тайланг ЗТХЯ-нд хүргүүлж редакцийн санал авсан байна.</p> | | | <p>бүлэг 32 гүйцэтгэх ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Олон улсын туршлага - Хот хоорондын зорчигч тээвэр төлөвлөлтийн хууль эрх зүйн орчин - Хот хоорондын зорчигч тээвэр төлөвлөлтийн өнөөгийн байдал - Хөдлөх бүрэлдэхүүний тоон болон чанарын үзүүлэлтүүдэд тодорхойлох статистик шинжилгээ хийн үр дүнг боловсруулах - Хот хоорондын зорчигч тээвэр төлөвлөлтийг сайжруулах аргачлал <p>Хүлээгдэж буй гүйцэтгэлээр төлөвлөгөөт хугацаандаа эхний шатны тайланг ЗТХЯ-нд 2022 оны 1/840 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> | |
| | | <p>1.13.4 ЗТХЯ болон үйлдвэрийн газрын гадна талбайд байрлуулсан нарны эх үүсвэрийн туршилт судалгааны ажил гүйцэтгэх Шалгуур үзүүлэлт: Судалгааны хэрэгжилтийн хувиар Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Эхний шатны тайланг ЗТХЯ-нд хүргүүлж редакцийн санал авсан байна.</p> | - | СХЧУТ | <p>"ЗТХЯ-ны гадна талбайд 40квт нарны эх үүсвэр суурилуулах" төслийн гүйцэтгэгч "Дүйнхэр тэргүүн" ХХК-тай хамтран судалгааны ажлыг эхлүүлсэн. Судалгааны ажлын даалгаврын хүрээнд ONGRID системийн цахилгаан үйлдвэрлэлийн өдөр тутмын үзүүлэлт, туршилтын хугацаан дах Улаанбаатар хотын цаг уур, агаарын бохирдолын хэмжээ, явган замын халаалтын системийн ажиллагаа зэрэг мэдээллийг цуглуулсан. Мөн нарны хавтан дээр унасан цас, түүний цэвэрлэх арга технологи зэргийг судлан боловсруулж байна. Тус яамны эрчим хүчний хэрэглээний талаар дэлгэрэнгүй мэдээллийг Засгийн газрын байрнуудын нийтлэг үйлчилгээний газар УТҮГ-аас авч судалгааны мэдээлэл боловсруулалт хийж байна. ЗТХЯ-нд 1/736 тоот албан бичгээр хугацаа сунгах хүсэлт явуулсан.</p> | 50 |
| 1.14 | Автотээврийн салбарын ажил үйлчилгээнд баталгаат үйлчилгээний тогтолцоог нэвтрүүлэх; | <p>1.14.1 Нийтийн зорчигч тээвэр болон автотээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуй нэгж, байгууллагад тохирлын үнэлгээ хийж, баталгаажуулалтын шийдвэр гаргах Шалгуур үзүүлэлт:</p> | - | СХЧУТ | <p>Тайлант хугацаанд нийт 17 иргэн, ААНБ тохирлын үнэлгээ хийлгэх өргөдөл ирүүлсэн ба ирсэн өргөдөл, холбогдох баримт бичигт дүн шинжилгээ хийж, баталгаажуулалтын үнэлгээг хийх боломжтой 12 иргэн, ААНБ-ын үйлчилгээнд баталгаажуулалтын үнэлгээг хийсэн. Мөн 2021, 2022 онд баталгаажуулалтын үнэлгээ хийсэн 16 иргэн, ААН-д тохирлын гэрчилгээ олгох шийдвэр гаргасан.</p> | 100 |

| | | | | | | |
|------|---|---|---|-------|---|-----|
| | | Тохирлын үнэлгээ хийж, баталгаажуулалтын шийдвэр гарсан ААНБ-ын тоо Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Өссөн дүнгээр хүсэлт ирүүлсэн 10-аас доошгүй ААНБ-д үнэлгээ хийж, шийдвэр гарсан байна. | | | | |
| | | 1.14.2 Салбарын хэмжээнд ашиглагдаж байгаа хэмжих хэрэгсэлд Олон улсын нэгжийн СИ системийн дагуу нэгж дамжуулах Шалгуур үзүүлэлт: Шалгалт тохируулга хийсэн хэмжих хэрэгслийн тоо Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Өссөн дүнгээр 100-аас багагүй хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийсэн байна. | - | СХЧУТ | Сонгинохайрхан, Баянзүрх техникийн хяналтын төвүүдийн нийт 108 ширхэг багажинд шалгалт тохируулга хийж, хэмжил зүйн шаардлага хангуулан гэрчилгээ олгосон. Мөн хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийлгүүлэхээр хүсэлт ирүүлсэн 9 ААНБ-ын 36 ширхэг багажид хэмжил зүйн ажил үйлчилгээ үзүүлж 750.700 төгрөгийг үйлдвэрийн газрын дансанд төвлөрүүлсэн. | 100 |
| 1.15 | Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох ажлыг зохих журамд заасны дагуу аймаг, орон нутагт зохион байгуулах; | 1.15.1. Авто үйлчилгээний байгууллагуудын судалгааг авч бүртгэлжүүлэх Шалгуур үзүүлэлт: Судалгааг гаргаж, яамыг мэдээллээр хангасан байх Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Орон нутгийн авто үйлчилгээний байгууллагын 2022 оны судалгааг авч, нэгтгэсэн байна | | АТХ | Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй авто үйлчилгээ эрхлэгчдийг бүртгэлжүүлэх зорилгоор судалгааны маягт боловсруулан, Аймгийн Автотээврийн төвүүдэд хүргүүлж, судалгааг нэгтгэж авсан. Аймгийн төвүүдэд үйл ажиллагаа явуулдаг 99 ААНБ, 366 иргэн буюу нийт 465 авто үйлчилгээ эрхлэгч байна. Үүнээс агрегат засварын үйлчилгээ үзүүлдэг 109, кузов засвар 36, явах эд ангийн засвар 145, цахилгаан засвар 38, дугуй засвар 81, авто угаалга 157, тос тосолгоо сэлбэгийн худалдаа 194, авто зогсоол 14, оёдол доторлогоо 6 тус тус үйл ажиллагаа явуулж байна. Аймаг бүрээр авч үзвэл Архангай 41, Баян-Өлгий 17, Баянхонгор 18, Булган 6, Говь-Алтай 37, Говьсүмбэр 12, Дархан-Уул 35, Дорноговь 8, Дорнод 23, Дундговь 18, Завхан 22, Орхон 53, Өвөрхангай 24, Өмнөговь 30, Сүхбаатар 21, Сэлэнгэ 23, Төв 7, Увс 9, Ховд 14, Хөвсгөл 10, Хэнтий 13, Замын-Үүд 11, Цогтцэций 13 авто үйлчилгээ эрхлэгч тус тус бүртгэгдэж, судалгаанд хамрагдсан байна. | 100 |

| | | | | | | |
|------|--|--|---|--------------|--|-----|
| | | <p>1.15.2. Ангилал тогтоох ажлыг аймаг орон нутагт зохион байгуулах</p> <p>Шалгуур үзүүлэлт: Ангилал тогтоож, гэрээ байгуулсан ААНБ-ын тоо</p> <p>Хугацаа: I-IV улирал</p> <p>Зорилтот түвшин: Орон нутагт 191 авто үйлчилгээний байгууллага ангилал тогтоолгож, үйлчилгээний төрлөөс хамааран 218 ангиллын гэрчилгээ авч гэрээ байгуулсан байна.</p> | - | <p>АТХ</p> | <p>Авто үйлчилгээний мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан 15 авто үйлчилгээний байгууллага нь 22 ангиллын гэрчилгээ авах хүсэлтээ цахимаар ирүүлсэн байна. Хүсэлтийг шалгаж үзэхэд холбогдох баримт бичгийн бүрдэл дутуу байсан тул орон нутгийн АТТ-үүдийн хариуцсан ажилтнуудтай холбогдон мэдэгдэж, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>ЗТХС-ын 2022 оны А/112 тоот "Журам шинэчлэн батлах тухай" тушаалаар Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам шинэчлэгдсэн батлагдсан. Уг журмыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан АТҮТ-ийн захирлын 2022.06.02-ны өдрийн А/145 тоот "Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох тухай" тушаал батлагдсан. Журмыг 2022.07.01-ний өдрөөс мөрдөж эхлэх бөгөөд холбогдох бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Өссөн дүнгээр 187 авто үйлчилгээ эрхлэгчдэд 216 ангиллын гэрчилгээ олгосон.</p> | 70 |
| 1.16 | <p>Ашиглалтаас хасагдсан автомашин, түүний эд ангийг устгах, дахин боловсруулах талаар холбогдох судалгааны ажлыг хийх, санал боловсруулах</p> | <p>1.16.1. Ашиглалтаас хасагдсан автомашин, түүний эд ангийг устгах, дахин боловсруулах талаар санал боловсруулах</p> <p>Шалгуур үзүүлэлт: Судалгааны ажлыг хийж, тайлагнасан байх</p> <p>Хугацаа: I-IV улирал</p> <p>Зорилтот түвшин: Хийгдсэн судалгааны дагуу холбогдох мэргэжлийн байгууллагуудаас санал авч боловсруулалт хийнэ.</p> | - | <p>АТХ</p> | <p>Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй авто үйлчилгээний байгууллага, уул уурхай, ашигт малтмал, хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамруулан тэдгээрийн ажил үйлчилгээний явцад үүссэн аюултай хог хаягдлыг судалгааг гарган санал боловсруулан 2021.06.02-ны өдрийн 2/690 тоот албан бичгээр ЗТХЯ-ны АТБХЗГ-т хүргүүлсэн. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй авто үйлчилгээний байгууллагын хог хаягдлыг судалгааг 2022 оны байдлаар шинэчлэн авахаар ажиллаж байна.</p> | 30 |
| 1.17 | <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, түүнд нийцүүлэн гарсан дүрэм, журам, стандартыг, осол мөрдүүлж, осол зөрчлөөс</p> | <p>1.17.1 "ХАБЭА-н мэдлэг олгох нийт ажилтны сургалт" зохион байгуулах</p> <p>Шалгуур үзүүлэлт: Сургалтад хамрагдсан ажилтны тоо</p> <p>Хугацаа: I-IV улирал</p> <p>Зорилтот түвшин:</p> | - | <p>СХЧУТ</p> | <p>2022.03.14-ний өдөр үйлдвэрийн газрын ХАБЭА-н сургалт явуулах гэрчилгээг 3 жилийн хугацаатай сунгасан. Тайлант хугацаанд нийт ажилтны сургалтыг 14 удаа зохион байгуулж, үйлдвэрийн газрын 370 ажилтан хамрагдаад байна.</p> | 100 |

| | | | | | | | |
|------|--|----------|---|--|------------|--|----|
| | урьдчилан сэргийлэх хэмжээг хэрэгжүүлэх; | арга авч | Сургалтанд өссөн дүнгээр 393 ажилтан хамрагдсан байна. | | | | |
| | | | 1.17.2 Улс, хот хоорондын ачаа, зорчигч тээврийн ААНБ-аас ирсэн хүсэлтийн дагуу "ХАБЭА-н мэдлэг олгох нийт ажилтны сургалт", "Ажил олгогч эздийн сургалт" зохион байгуулах. Шалгуур үзүүлэлт: Сургалтад хамрагдсан ажилтны тоо Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Сургалтанд өссөн дүнгээр 100 ажилтан хамрагдсан байна. | | СХЧУТ | Үйлдвэрийн газрын нийт ажилтнуудад ХАБЭА -н сургалт явуулж байгаатай холбогдуулан салбарын хэмжээнд явуулах сургалтыг 3-4-р улиралд зохион байгуулах бэлтгэл ажлыг бүрэн хангасан. | 30 |
| | | | 1.17.3 ЗТХЯ-аас гаргасан шалгуур үзүүлэлт бүрийн дагуу үйлдвэрийн газраас 2022 онд ХАБЭА-н чиглэлээр хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, шаардлагатай нөөцөөр ханган хэрэгжилтийг тухай бүр тайлагнах. Шалгуур үзүүлэлт: Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын биелэлт 40-өөс доошгүй хувь хангагдсан байна. | | СХЧУТ | "АТУТ" ТӨҮГ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр 2022 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг ЗТХЯ-с гаргасан шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу боловсруулж Зам, тээврийн хөгжлийн дэд сайд, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны дарга Ж.Бат-Эрдэнэд 2022 оны 1/242 тоот албан бичгээр хүргүүлсэн. Төлөвлөгөөнд тусгагдсан 3 зорилтын хүрээнд 24 арга хэмжээг хэрэгжүүлэх ба төлөвлөгөөний гүйцэтгэлийг 1 дүгээр улирлын байдлаар гаргаж, ЗТХЯ-нд 2022 оны 1/620 тоот албан бичгээр хүргүүлсэн. Төлөвлөгөөний гүйцэтгэлд хагас жилийн байдлаар үнэлгээ хийж ЗТХЯ-нд хүргүүлэхээр боловсруулж байна. | 70 |
| 1.18 | "Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын | | 1.18.1 Дотоодын ачаа тээврийг бүртгэлжүүлэх, програм хангамжийг улсын хэмжээнд нэвтрүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах Шалгуур үзүүлэлт: | | АТХ МТХ | Дотоодын ачаа тээврийн цахим системийн мобайл апп хөгжүүлэлтийг Андроид болон IOS үйлдлийн системд зориулан хийж гүйцэтгэж дууссан. Андроид гар утсанд зориулагдсан хувилбар google playStore, IOS үйлдлийн системтэй гар утас болох iphone-д зориулагдсан хувилбар AppStore-д байршуулсан. Орон нутгийн автотээврийн салбар төвүүдэд мэдээлэл хүргүүлсэн. | 50 |

| | | | | | | |
|--|--|-------------------------------|--|------------|--|----|
| 2018 оны 259 дүгээр тогтоолын дагуу автотээврийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлэх; | Дотоодын ачаа тээврийн үйлчилгээг цахимаар авах боломж бүрдсэн байх Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Дотоодын ачаа тээврийн цахим системийн гар утсанд суурилсан хувилбарыг үйлчилгээнд туршсан байна. | | | | | |
| | 1.18.2 Авто үйлчилгээний мэдээллийн сангийн найдварт ажиллагааг ханган нэмэлт хөгжүүлэлт хийх Шалгуур үзүүлэлт: Авто үйлчилгээний мэдээллийн санд хөгжүүлэлт хийсэн тоо Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Авто үйлчилгээний мэдээллийн санд 1 нэмэлт хөгжүүлэлт хийсэн байна. | - | | ATX MTX | Авто үйлчилгээний мэдээллийн санд нэмэлт хөгжүүлэлт хийж, ангилал тогтоолгосон авто үйлчилгээ эрхлэгч нь мэдээллийн нэгдсэн санд тээврийн хэрэгсэлд хийж гүйцэтгэсэн засвар үйлчилгээний мэдээлэл оруулж, засварын түүх үүсгэснийг он оноор нь excel программаар татах боломжтой болсон | 70 |
| | 1.18.3 Улс хоорондын байнгын ачаа тээврийн зөвшөөрлийг "e-mongolia" порталаар олгох нөхцөлийг бүрдүүлэх; Шалгуур үзүүлэлт: Зөвшөөрлийг И-Монгол порталаар олгож эхэлсэн байх Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Зөвшөөрлийг И-Монгол порталаар олгож эхлүүлсэн байна. | 40.0 сая төгрөг /Улсын төсөв/ | | ATX MTX | Улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлт ашигладаг хил нэвтрэх С төрлийн зорчих зөвшөөрлийн бичиг олгох ажлыг "e-mongolia" портал сайтаар дамжуулан олгох ажлын хүрээнд тус үйлдвэрийн газрын тээврийн нэгдсэн системийн мэдээллийн санг "e-mongolia" портал сайтын мэдээллийн сантай холбох ажлыг хийж дуусгасан. ЗТХЯ-ны 2022.03.11-ний өдрийн 07/1099 тоот албан бичгээр "e-mongolia" портал сайтаар дамжуулан хил нэвтрэх С төрлийн зорчих зөвшөөрлийн бичгийг олгох ажлыг гадаадын иргэний бүртгэлтэй холбоотой асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран бүрэн шийдвэрлэсний дараа нэвтрүүлэх чиглэл өгсөн. Гадаадын иргэн "e-mongolia" портал сайтад нэвтрэх боломжийг тус портал сайт хөгжүүлэгч хийж дуусаагүй байгаа тул хүлээгдэж байна. | 70 |

| | | | | | | |
|------|---|---|---|-------|--|----|
| 1.19 | Орон нутагт автотээврийн ажил үйлчилгээг хариуцан гүйцэтгэхдээ тухайн аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулан хэрэгжилтийг хангуулах үр дүнг тооцох | 1.19.1 Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээг дүгнэх, үр дүнг тооцох Шалгуур үзүүлэлт: 21 аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээг дүгнэсэн байх Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: 2021 оны гэрээг дүгнэж, үр дүнг тооцсон байна. | - | ЗСХНХ | 2022 онд 19 аймгийн засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулснаас нийт гэрээг дунджаар 78,9 хувьтай дүгнэн ажилласан байна. | 70 |
| | | 1.19.2 Аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулах Шалгуур үзүүлэлт: 21 аймгийн Засаг даргатай гэрээ байгуулсан байх Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: 21 аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулагдсан байна. | - | ЗСХНХ | 2021 онд байгуулсан хамтран ажиллах гэрээ нь 2022.12.31-ныг хүртэл хүчинтэй бөгөөд шинээр томилогдсон 4 орон нутгийн төвийн дарга нар хамтран ажиллах гэрээгээ хүргүүлсэн байна. | 70 |
| 1.20 | Гэрээний үндсэн дээр хариуцуулан гүйцэтгэх ажил үйлчилгээг шуурхай зохион байгуулах зорилгоор бусад холбогдох эрх зүйн акттай уялдуулж шаардлагатай дүрэм, журам, стандартыг шинээр боловсруулах, шинэчлэн сайжруулах чиглэлээр санал | 1.20.1 Автотээврийн салбарын чанарын дэд бүтцийг бэхжүүлэх чиглэлээр 5 стандарт шинээр боловсруулах. Шалгуур үзүүлэлт: Боловсруулсан стандартын тоо Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Сонирхогч талуудаас санал авсан байна. | - | СХЧУТ | Автотээврийн салбарын стандартчиллын техникийн хороо /ТХ-15/-ны 2022.03.04-ний өдрийн хуралдаанаар дараах стандартуудыг хэлэлцүүлж батлуулсан. Үүнд: 1. MNS ...-2022 Тээврийн хэрэгслийн резин дугуй засварын үйлчилгээ. Ерөнхий шаардлага. 2. MNS ...-2022 Автотээврийн хэрэгслийн их биеийн засвар, үйлчилгээний байгууллагад тавих шаардлага 3. MNS ...-2022 Автотээврийн хэрэгслийг тос, тослогооны болон ашиглалтын материалаар цэнэглэх үйлчилгээ. Ерөнхий шаардлага. | 70 |
| | | 1.20.2 Авто үйлчилгээ эрхлэгчдэд ангилал тогтоох, хяналт тавих журмыг шинэчлэн батлуулахтай холбогдуулан бусад дагаж мөрдөх бичиг баримтад өөрчлөлт оруулах | - | АТХ | ЗТХС-ын "Журам шинэчлэн батлах тухай" 2022 оны А/112 дугаар тушаалаар Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам шинэчлэгдсэн батлагдсан. Уг журмыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан үйлдвэрийн газрын захирлын "Авто үйлчилгээний байгууллагад ангилал | 70 |

| | | | | | | |
|------|---|--|-------------------------------|-----|---|----|
| | гаргах, холбогдох дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэх; | <p>Шалгуур үзүүлэлт: Санал боловсруулж, холбогдох газарт хүргүүлсэн байх</p> <p>Хугацаа: III-IV улирал</p> | | | тогтоох тухай" 2022.06.02-ны өдрийн А/145 дугаар тушаал батлагдан гарсан. | |
| | | <p>1.20.3 LPG хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх стандартад холбогдах байгууллагуудаас саналыг авч Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлэх.</p> <p>Шалгуур үзүүлэлт: Холбогдох байгууллагуудаас санал авч, СХЗГ-т хүргүүлсэн байх</p> <p>Хугацаа: I-IV улирал</p> <p>Зорилтот түвшин: Стандартын төслийг боловсруулсан байна.</p> | - | TXX | Хийгээр ажилладаг автотээврийн хэрэгслийн хаягдал утаан дахь хорт бодис, нэмэлт шаардлагыг шалгах талаар стандартын төслийг боловсруулсан. Холбогдох байгууллагуудаас санал авахаар төлөвлөж байна. | 50 |
| 1.21 | Зам, тээврийн салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах дунд хугацаа (2020-2024)-ны дэд хөтөлбөрийн хүрээнд; | <p>1.21.1 Зам, тээврийн салбарын энтерпрайз архитектур, төлөвлөлтийн нэгдсэн платформыг өөрсдийн үйл ажиллагаандаа иж бүрэн нэвтрүүлж, байгууллагынхаа энтерпрайз архитектурын чиг үүрэг, үйл ажиллагааг хариуцан ажиллах ажлын байр, албан тушаалтнуудыг тусгайлан томилж, эдгээр үйл ажиллагаагаа яамны бодлого, төлөвлөлттэй нягт уялдуулж, дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллах.</p> <p>Шалгуур үзүүлэлт: Ажлын явц хувиар</p> <p>Хугацаа: I-IV улирал</p> <p>Зорилтот түвшин:</p> | Улсын төсөв, дотоодын зөвсвэр | MTX | <p>Үйлдвэрийн газраас "Интерактив" ХХК-тай байгуулсан Санамж бичгийн хүрээнд "Зам, тээврийн салбарын нэгдсэн платформ" хөгжүүлэх сургалтанд МТХ-ийн 4 мэргэжилтэн хамрагдсан.</p> <p>Мөн ЗТХЯ-ны 2022.03.07-ны өдрийн 03/1024 тоот албан бичгийн дагуу тус үйлдвэрийн газрын 5 мэргэжилтэн удирдамжийн дагуу 2022.07.01-ний өдрийг хүртэл хугацаа сунгагдан "Зам, тээврийн салбарын нэгдсэн платформ"-ыг хөгжүүлэх ажилд оролцож байна.</p> | 70 |

| | | | | | | |
|--|--|---|---|-----|--|----|
| | | Одоогийн архитектурыг тодорхойлж, эмзэг цэгийг тодруулах, үйл ажиллагааг үнэлэх, шинжлэх ажлыг хэрэгжүүлсэн байна. | | | | |
| | | 1.21.2 Байгууллагынхаа хэмжээнд кибер (мэдээллийн) аюулгүй байдлын эрсдэлийн иж бүрэн шинжилгээ, үнэлгээ хийлгэж, кибер (мэдээллийн) аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо бүрдүүлэх, аюулгүй байдлын архитектураа төлөвлөх талаар цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх. Шалгуур үзүүлэлт: Ажлын явц, хувиар Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Санал, зөвлөмжийн дагуу холбогдох үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж эхэлсэн байна. | Улсын төсөв, дотоодын эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл | MTX | Тус үйлдвэрийн газрын Мэдээллийн технологийн хэлтсээс "SSSC" ХХК-ийн мэдээллийн аюулгүй байдлын мэргэжилтэнтэй холбогдож, эрсдэлийн үнэлгээ хийх цар хүрээг тогтоосон. Уг зөвлөх үйлчилгээтэй холбоотой зардлыг шийдвэрлэхээр ТӨБЗГ-т 2022.02.18-ний өдрийн А-1/310 тоот бичгээр хүсэлт хүргүүлсэн. ТӨБЗГ-аас шаардлагтай тоног төхөөрөмжийг сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаар борлуулсны орлогын эх үүсвэрээс санхүүжүүлэхийг чиглэл болгосон. Үүнтэй холбогдуулан ХНХЯ-нд 2022.04.15-ний өдрийн 2/490 албан бичгээр улсын дугаарын дуудлага худалдаанаас төвлөрсөн сангаас шийдвэрлүүлэхээр хүсэлт хүргүүлсэн. ХНХЯ-наас 2022.04.29-ний өдрийн 01/1176 тоот албан бичгээр дээрх зардлыг шийдвэрлэх хөрөнгийг автотээврийн хэрэгслийн сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаар борлуулсны орлогоос санхүүжүүлэх нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нийцэхгүй байгаа тул боломжгүй байна гэсэн хариу ирүүлсэн. | 30 |
| | | 1.21.3 Байгууллагынхаа нийт компьютерын 30-аас дээш хувийг албан ёсны байнгын ашиглах эрх (лиценз)-тэй үйлдлийн систем болон оффисын программ хангамжтай болгож, аюулгүй байдлыг хангах. Шалгуур үзүүлэлт: Ажлын явц, хувиар Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: Зорилт, арга хэмжээний 50-аас багагүй хувийг хэрэгжүүлсэн байна. | Улсын төсөв, дотоодын эх үүсвэр | MTX | Үйлдвэрийн газарт ашиглагдаж байгаа зөөврийн болон суурин компьютерүүдийн 30 хувь буюу 140 ширхэг компьютерт шаардлагатай лицензийн үнийн саналыг 3Zeissoftware Digital Limited3 LLC, 3Эксотик девелопмент3 ХХК, "Ашим" ХХК, "Мобинет" ХХК зэрэг албан ёсны лиценз нийлүүлэгч аж ахуй нэгжүүдээс үнийн санал аван төсөвт тодотгол оруулах саналыг хүргүүлээд байна. | 30 |

| | | | | | | |
|--|--|--|--|----------------------|--|-----------|
| | | <p>1.21.4 Зам, тээврийн салбарын мэдээллийн нэгдсэн платформ дээр суурилсан дэд систем, модуль хөгжүүлэлтүүдийг шуурхай хэрэгжүүлж, уг ажилд шаардлагатай платформ ашиглах эрх (лиценз)-ийг авч, өөрийн ажилтнуудыг энэ чиглэлээр сургаж мэргэшүүлэн, эдгээрт шаардлагатай санхүүжилт, хөрөнгө оруулалтаар нь хангаж, энэ талаар яамнаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаатай нягт уялдуулж, дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллах.</p> <p>Шалгуур үзүүлэлт: Ажлын явц, хувиар</p> <p>Хугацаа: I-IV улирал</p> <p>Зорилтот түвшин: Платформ дээр суурилсан дэд систем, модуль хөгжүүлэлтийг хэрэгжүүлж, эдгээрийг яамны бодлого, төлөвлөлттэй нягт уялдуулж, дэмжлэг үзүүлж, хамтарч ажилласан байна.</p> | <p>Улсын төсөв, дотоодын эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн н түншлэл</p> | <p>MTX</p> | <p>ЗТХЯ-ны 2022.03.07-ны өдрийн 03/1024 тоот албан бичгийн дагуу тус үйлдвэрийн газрын 5 мэргэжилтэн "Зам, тээврийн салбарын нэгдсэн платформ"-ын модуль хөгжүүлэх ажлыг гүйцэтгэж байна. Үйлдвэрийн газрын цахим шилжилтийг хийхэд шаардлагатай системүүд дээр нээлттэй сервисийг гаргаж, туршилт тохируулгын ажлыг хийж дуусгасан.</p> <ul style="list-style-type: none"> - тээврийн хэрэгслийн бүртгэл - мэргэшсэн жолооч - Авто үйлчилгээний систем - Техникийн хяналтын үзлэгийн систем - Тээврийн нэгдсэн систем - Дотоодын ачаа тээврийн систем | <p>70</p> |
| | | <p>1.21.5 Тухайн байгууллага өөрсдийн чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд дэвшилтэд техник технологи, инновацийн талаар туршлага судлах, хамтын ажиллагаа өрнүүлэх, судалгаа хийх.</p> <p>Шалгуур үзүүлэлт: Судалгааны ажлын тоо</p> <p>Хугацаа: I-IV улирал</p> <p>Зорилтот түвшин:</p> | <p>Улсын төсөв, гадаад, дотоодын эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн н түншлэл</p> | <p>MTX СХЧУТ</p> | <p>Үйлдвэрийн газрын албан хаагчдын бүтээлч сэтгэхүй, санал санаачлагыг нэмэгдүүлэх замаар үйлчилгээний чанар, хүртээмж, аюлгүй байдлын түвшинг нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Энэ хүрээнд үйлдвэрийн газрын хэмжээнд "Зөв хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхээр ажлын хэсгийг байгуулж, дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Үйлдвэрийн газрын бүтцийн нэгжүүдийн оролцоог хангасан ажлын хэсгийг байгуулсан 2. Зөв хөтөлбөрийг амжилттай нэвтрүүлсэн "Тэсо" ххк -ны туршлагыг судалсан. 3. Монголын бүтээмжийн төвөөс 10 цагийн практик сургалтыг авч нийт 70 албан хаагчийг хамруулсан. | <p>70</p> |

| | | | | | | |
|--|--|---|---|------------|---|----|
| | | Ажлын цар хүрээгээ тогтоож, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж эхэлсэн байна. | | | | |
| | | <p>1.21.6 Байгууллагынхаа ажилтан, албан хаагчдын тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэн, албан хэрэг хөтлөлтөд ашиглаж, тоон гарын үсэг болон QR кодоор баталгаажуулсан цахим албан бичиг солилцоог бүрэн хэмжээнд нэвтрүүлэх.</p> <p>Шалгуур үзүүлэлт: Ажлын явц, хувиар</p> <p>Хугацаа: I-IV улирал</p> <p>Зорилтот түвшин: Тоон гарын үсэг болон QR кодоор баталгаажуулсан цахим албан бичиг солилцоог нэвтрүүлсэн байна.</p> | Улсын төсөв, дотоодын эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл | MTX | 2022.05.01-ний өдрөөс цахим гарын үсгийн тухай хууль мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан тус үйлдвэрийн газар нь "Үндэсний Дата Төв" УТҮГ-тай тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, хамтран ажиллах гэрээ байгуулан зохих албан тушаалтнуудад нийт 125 ширхэг тоон гарын үсгийн гэрчилгээг олгоод байна. | 50 |
| | | <p>1.21.7 Өөрсдийн чиг үүргийн хүрээнд цахимжуулсан үйлчилгээ, үйл ажиллагааныхаа талаар иргэд, олон нийтэд сурталчлан таниулах.</p> <p>Шалгуур үзүүлэлт: Тухайн байгууллагын өнөөгийн түвшин</p> <p>Хугацаа: I-IV улирал</p> <p>Зорилтот түвшин: Тухай бүр цахимжуулсан үйлчилгээ, үйл ажиллагааныхаа талаар иргэд, олон нийтэд сурталчлан таниулсан байна.</p> | Дотоодын эх үүсвэр | ЗСХНХ | Дотоодын ачаа тээврийн цахим системийн мобайл апп хөгжүүлэлтийг Андроид болон IOS үйлдлийн системд зориулан хийж гүйцэтгэж дууссан. Андроид гар утсанд зориулагдсан хувилбар google playStore, IOS үйлдлийн системтэй гар утас болох iphone-д зориулагдсан хувилбар AppStore-д байршуулсан. Энэ талаар олон нийтэд мэдээлэл хүргэсэн. | 70 |
| | | 1.21.8 Зорчигчийн нэгдсэн тасалбар нэвтрүүлж, уг ажлыг бусад байгууллага, нэгжүүдийн үйл ажиллагаатай нягт уялдуулж, | Улсын төсөв, дотоодын эх | MTX ЗТХ | Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Tapatrip, Social Pay, SkyTicket зэрэг нэгдсэн платформууд дээр нэгэн зэрэг автотээвэр, иргэний нисэх, төмөр замын зорчигч тээврийн тасалбаруудыг борлуулж байна. Заавал 1 тасалбар дээр | 70 |

| | | | | | |
|--|---|---|-----|--|----|
| | <p>дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллах.</p> <p>Шалгуур үзүүлэлт: Цахим тасалбар худалдан авалтын эзлэх хувь</p> <p>Хугацаа: I-III улирал</p> <p>Зорилтот түвшин: Гэрээний дагуу тасалбар борлуулах системийн хөгжүүлэлтийг эцэслэн дуусгаж, туршилт хийгдсэн байна.</p> | үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл | | гаргах шаардлагагүйгээр 1 платформ дээрээс аль ч билетээ авах боломжоор хангасан. 2022 оны эхний хагас жилийн байдлаар 3132 захиалгыг уг нээлттэй сервисээр дамжуулан хүлээн авсан байна. | |
| | <p>1.21.9 Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ (RFID tag)-г бүрэн нэвтрүүлж, татвар даатгал, төлбөр тооцоо, бүртгэл хяналтын үйл ажиллагааг сайжруулах.</p> <p>Шалгуур үзүүлэлт: Хэрэгжилтийн байдлаар</p> <p>Хугацаа: I-IV улирал</p> <p>Зорилтот түвшин: Холбогдох шийдвэрийг үндэслэж техникийн хяналтын цахим гэрчилгээ (RFID tag)-г автотээврийн хэрэгсэлд байрлуулах ажлыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн байна.</p> | Улсын төсөв, дотоодын эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл | MTX | Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ /RFID/-г урьдчилан бэлгэх, тээврийн хэрэгсэлд байрлуулах, бүртгэх үйл ажиллагааны 2022 оны нарийвчилсан төлөвлөгөө ЗТХЯ дээр боловсруулагдаж байна. Мөн техникийн хяналтын үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгсэлд RFID шошго суурилуулах ажлын хэсэг ЗТХЯ дээр байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд үйлдвэрийн газраас шаардлагатай мэдээллүүдийг гарган өгч, хамтран ажиллаж байна. | 70 |
| | <p>1.21.10 Автотээврийн хэрэгслийн бүртгэлийн системийг сайжруулах, хөгжүүлэх талаар цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх.</p> <p>Шалгуур үзүүлэлт: Хэрэгжилтийн байдлаар</p> <p>Хугацаа: I-IV улирал</p> <p>Зорилтот түвшин:</p> | Дотоодын эх үүсвэр | MTX | Тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйлчилгээг цахимаар үзүүлэх чиглэлээр "VRS" системд "Гааль", "Татварын ноогдолтой эсэх", "Нотариат"-ын сервис холбож дууссан. Уг сервисийг холбосноор иргэн гэрээний материал цаасаар авчиргах шаардлагагүй болсон бөгөөд тухайн иргэнтэй хийсэн гэрээг цахимаар солилцдог болсон. Мөн бүртгэлийн мэргэжилтний ажлын үр бүтээмжийн дээшлүүлж аливаа хуурамч бичиг баримт, залилангаас хамгаалах үр ашигтай ажил болсон. Програмчлалын хувьд нотариатын сервистэй холбогдсоноор цахим маягт дээр тухайн А-тал, Б-талын мэдээллийг бүртгэлийн цахим архивт | 70 |

| | | | | | | |
|--|-----|--|--|--|---|------|
| | | Судалгааны ажлын үр дүнгийн дагуу сайжруулах, хөгжүүлэх ажлыг хэрэгжүүлж, хэвийн тасралтгүй ажиллагааг хангасан байна. | | | давхар хадгалж, PDF форматаар автоматаар хадгалж архивладаг болсон. Одоогийн байдлаар тээврийн хэрэгслийн даатгалтай эсэх сервис хүлээгдэж байна. | |
| | ДҮН | | | | | 71.0 |

Танилцсан:

"АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ

Б.ГҮРСОРОНЗОН

Хянасан:

ЗАХИРГАА, СУРГАЛТ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.БААТАРЦОЛ

Нэгтгэсэн:

ЗАХИРГАА, СУРГАЛТ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

М.ЭНХЗАЯА